БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

ДОТООДЫН ХЯНАЛТ САЙЖРУУЛЖ, ҮР АШИГГҮЙ ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”

2025 оны 11 дүгээр сар

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: У.Ербол
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Нурлан

Утас: 99103281, Цахим хаяг Nurlans@audit.gov.mn

Аудитор: М.Айнур
Утас: 99423031 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn
Аудитор: Х.Еркебулан
Утас: 99999844 Цахим хаяг:erkebulankh@ audit.gov.mn
Аудитор:Р. Баярмаа
Утас: 99265539 Цахим хаяг: Bayarmaar@audit.gov.mn
Аудитор:Ш.Нурлан
Утас: 99422966 Цахим хаяг: NurlanSH@audit.gov.mn
Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuyab@audit.gov.mn

Аудитор Ж.Назгүл

Утас: 99668909, Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

2025 он

АГУУЛГА.....1
АУДИТЫН СЭДЭВ: "ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ".....1
Товчилсон үгийн тайлбар.....3-4
Ерөнхий мэдээдэл…… ……7
БҮЛЭГ 1. ОНӨААН-ҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ҮР АШИГГҮЙ БАЙНА.....8
1.1. ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ХЯНАЛТ НЬ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....8
1.1.1.Төлөвлөн удирдах зөвлөлийн бодлого, шийдвэрийн үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.....8
1.1.2.Эдийн засгийн зорилтот түвшний зарим үзүүлэлтийг бодитой төлөвлөөгүй байна.....9
1.1.3. ЦШСГ нь зорилтот түвшний зарим үзүүлэлтийг бодитой хянаагүй байна..... 122
1.2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР ДҮНТЭЙ, ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАСАН БАЙНА……14
1.2.1. ЦШСГ нь үйл ажиллагааны зорилт түвшнийг хангаж ажиллах шаардлагатай байна..... 14
1.2.2 ЦШСГ нь бусад орлогыг үнэн зөв тайлагнаагүй, зарим орлогыг дутуу төвлөрүүлсэн байна..19
1.2.3 Удирдлагын зардлын төлөвлөлт, хяналт хангалтгүй байна.....27
1.2.4 Үр ашиггүй зардлыг бууруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар хангалтгүй ажилласан байна..... 29
1.2.5. Худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй байна……..34
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.....36
2.1.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАСАН БАЙНА.....36
2.1.1. Эрх бүхий байгууллагуудаас хяналт шалгалт хийгдсэн байна.....36
2.1.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийсэн байна..... 37
2.2. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА 38
2.2.1 ТУЗ-өөс хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна 38
2.2.2. Дотоод хяналтыг үр нөлөөтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна 39
2.2.3. Шилэн дансны зарим мэдээллийг ил тод байршуулаагүй байна 40
ДҮГНЭЛТ: 41
ЗӨВЛӨМЖ.....42

№

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
ББЭХ	Баруун бүсийн эрчим хүч
БОХШ	Боруулалтын орлогын шаардагдах хэмжээ
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НААҮГ	Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ТБОНӨХБАҮХАТ хууль	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТЗБАХ	Техник, зохион байгуулалтын арга хэмжээ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮТГ	Үнэ тарифын газар
ХСУХАТАҮ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг
ХАЦӨ	Худалдан авах цахилгааны өртөг
ХХОАТ	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХК	Хувь хүний орлогын албан татвар
ЦШСГ	Цахилгаан шугам сүлжээний газар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХЯ	Эрчим хүчний яам

Хүснэгтийн товьёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	*ЦШСГ-ын 2023-2024 оны зорилтот түвшний төлөвлөлт*	*9*
Хүснэгт 2	*“Суат” ХХК-ийн бизнес, эдийн засгийн 2022 оны төлөвлөгөөг суурь болгож 2023-2024 оныг харьцуулсан судалгаа*	*11*
Хүснэгт 3	*“Суат” ХХК-ийн өмнөх оны гүйцэтгэлтэй тухай жилийн төлөвлөгөө уялдсан эсэх талаарх судалгаа*	*11*
Хүснэгт 4	*ҮТГ-аас ЦШСГ-ын 2023-2024 оны төлөвлөлтийг хянасан байдал*	*12*
Хүснэгт 5	*ЦШСГ-ын зорилтот түвшиний билэлтийн судалгаа*	*14*
Хүснэгт 6	*ЦШСГ-ын 2023-2024 оны зардлын бүтцийн судалгаа*	*16*

Хүснэгт 7	*ЦШСГ-ын 2023-2024 оны авлагын судалгаа*	*17*
Хүснэгт 8	*ЦШСГ-ын 2023-2024 оны БХӨТ-ийн судалгаа*	*17*
Хүснэгт 9	*"Суат" ХХК-ийн үйл ажиллагааны орлого, зардлын төлөвлөлт, гүйцэтгэл*	*17-18*
Хүснэгт 10	*ЦШСГ-ын 2023-2024 оны орлогын судалгаа*	*19*
Хүснэгт 11	*"Суат" ХХК-ийн төслийн орлого, зардлын судалгаа*	*21*
Хүснэгт 12	*"Суат" ХХК-ийн 2023-2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа*	*25*
Хүснэгт 13	*"Суат" ХХК-ийн борлуулалтын орлогыг хэрэглэгчээр ангилсан судалгаа*	*26*
Хүснэгт 14	*"Суат" ХХК-ийн цэвэр усны шугамд холбогдсон хэрэглэгчийн судалгаа*	*26*
Хүснэгт 15	*"Суат" ХХК-ийн авлагын харьцуулсан судалгаа*	*27*
Хүснэгт 16	*"Суат" ХХК-ийн удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа*	*28*
Хүснэгт 17	*ЦШСГ-ын 2023-2024 оны зардлын судалгаа*	*29*
Хүснэгт 18	*ЦШСГ-ын цалин, урамшууллын зардал, орон тооны судалгаа*	*30*
Хүснэгт 19	*"Суат" ХХК-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа*	*31-32*
Хүснэгт 20	*"Суат" ХХК-ийн бүтэц орон тооны судалгаа*	*33*

Графикийн товьёог

№	Тайлбар	Хуудасны дугаар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв.Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд: • Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх; • Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн хяналт үр нөлөөтэй эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Баян-Өлгий аймгийн орон нутгийн өмчийн “Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ, “Суат” ХХК-ийн 2023-2024 оны үйл ажиллагаа, бизнес санхүүгийн төлөвлөгөө, түүний биелэлт, техник эдийн засгийн үзүүлэлт, санхүү, төсвийн зарцуулалттай холбогдолтой материалыг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.
Аудитын хязгаарлалт	Байхгүй
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020 “Чанарын хяналт”, 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудит”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Ербол, С.Нурлан, аудитор М.Айнур, Х.Еркебулан, Р.Баярмаа, Ш.Нурлан, Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл нар хамтран гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний хооронд гүйцэтгэж, аудитын дэд тайланг бэлтгэх ажлыг 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 10 дугаар сарын 22-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Аудитын нэгдсэн тайлангийн төслийг 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний хооронд бэлтгэж, хянуулан баталгаажуулав.Аудитын явцад төрийн зарим байгууллагуудаас мэдээлэл авах, тайлбар тодруулга авахад нэмэлт хугацаа шаардлагатай болсон тул аудитын хугацааг сунгасан болно.
Хүндрэл бэрхшээл	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн удирдлагад ажиллаж байсан зарим албан тушаалтнууд ажлаас өөрчлөгдснөөс аудитад шаардлагатай баримт материал гаргуулж авах, тайлбар тодруулга авахад хүндрэл учруулав.

Ерөнхий мэдээлэл

“Баян-Өлгий аймгийн ЦШСГ” ОНӨААТҮГ-ын талаар:

Баян-Өлгий аймгийн төвд 1954 онд ДТ-54 маягийн дизель станц суурилуулснаар эрчим хүчний үйлдвэрийн анхны суурь тавигдсан байна. Улмаар 1952-1965 онд дизель станцаар, 1965-185 онд Чехославак улсын техник, эдийн засгийн тусламжтайгаар баригдсан 3 мВт-н хүчин чадалтай дулааны цахилгаан станц, 1982-1997 онд 4512 кВт-ын дизелийн цахилгаан станцаар хэрэглэгчдийг цахилгаанаар хангаж байжээ.

Баруун бүсийн нэгдсэн сүлжээнд ЦШСГ нь 1997 онд холбогдож, улмаар 13 сум, 1 тосгон өндөр хүчний шугамд холбогдож байнгын цахилгаан эрчим хүчээр хангагдсан байна.

Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 1999 оны шийдвэрээр “ Эрчим хүч” ХК-ын бүтцийг өөрчилж “цахилгаан түгээх, цахилгаанаар хангах” үүрэг бүхий “Баян-Өлгий аймгийн ЦШСГ” ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

УИХ-ын 1997 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Баян-Өлгий аймгийн ЦШСГ-ыг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ны талаар:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг НААҮГ-ын даргын 1999 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар тус аймгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагыг орон нутгийн өмчийн “Суат” ХХК болгон өөрчлөн компани хэлбэрээр зохион байгуулж, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

Орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ны ТУЗ-ийн 1999 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 01 дугаар тогтоолоор компанийн оноосон нэр, дүрмийг баталж, ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлагыг томилсон байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор “Суат” ХХК-ны ТУЗ-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй, 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэй, аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 130 дугаар тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор компани дүрэм болон ТУЗ-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан байна.

БҮЛЭГ 1. ОНӨААН-ҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ҮР АШИГГҮЙ БАЙНА

1.1. ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ХЯНАЛТ НЬ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн бодлого, шийдвэрийн үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна

“Баян-Өлгий аймгийн ЦШСГ-ын дотоод дүрэм”-ийг анх аймгийн Засаг даргаар батлуулсан ба дүрмээр байгууллагын зохион байгуулалт, удирдлага, бүтэц үйл ажиллагааны зарчмын харилцааг зохицуулсан бөгөөд Удирдах зөвлөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна. ЦШСГ нь 2025 он хүртэл үйл ажиллагаандаа дээрх дүрмийг удирдлага болгон ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 172 дугаар тогтоолоор ЦШСГ-ын Удирдах зөвлөлийн (УЗ) бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан байна. *(аймгийн ИТХ-ын 2020.12.27-ны өдрийн 101 дүгээр тогтоол хүчингүй болсон)*

Удирдах зөвлөл нь 2024 онд үйл ажиллагаатай холбоотой 2023-2024 онд цалин нэмэх, үр дүнгийн урамшуулал олгохтой холбоотой 6, ээлжийн амралт олгохтой холбоотой 3 тогтоол гаргаж, байгууллагын үйл ажиллагааг 2 удаа “хангалттай” гэж дүгнэсэн байна.

Илрүүлэлт:

ЦШСГ-ын ТУЗ нь тус газрын засаглал, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар үр дүнтэй бодлого, шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 38 дугаар тогтоолоор ЦШСГ-ын дүрэм, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, ТУЗ-ийн эрх, үүргийн талаар тусгаж улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Цахилгаан шугам сүлжээний газрын засаглал, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар бодлого, шийдвэр гаргаж ажиллахыг зөвлөмж болгов.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооноос “Суат” ХХК-ийн компанид 2025 оны 09 дүгээр сард хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын хэсгийн нэгдсэн тэмдэглэлд “Суат” ХХК-ийн ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байгаа нь бусад аймгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын ТУЗ-ийн бүрэлдэхүүнээс 80 хувиар өндөр байгааг тогтоож, үйл ажиллагааны зардлыг хэмнэж, аймгийн ИТХ-ын тогтоолд өөрчлөлт оруулан компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний тоог бусад аймгийн жишигт хүргэх талаар тодорхой дурдсан байна.

Компанийн дүрмийн 6.1.9-т “ТУЗ-ийн ажиллах журмыг удирдах зөвлөл өөрөө тогтооно” гэж заасан боловч ТУЗ-ийн ажиллах журмыг баталж ажиллаагүй байна.

“Суат“ ХХК-ийн ТУЗ нь 2023 онд 6 удаа хуралдаж 10 тогтоол, 2024 онд 2 удаа хуралдаж 5 тогтоол гаргасан байна. ТУЗ-ийн хурлаас “Суат” ХХК 2022, 2023 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэсэн бол 2024 оны үйл ажиллагааг дүгнээгүй байна.

“Суат” ХХК-ны ТУЗ нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталж, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар бодлого, шийдвэрүүдийг гаргахад анхаарах нь зүйтэй байна.

Компанийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавьж ажиллах, үр ашгийг дээшлүүлэхийг зөвлөмж болгов.

1.1.2. Эдийн засгийн зорилтот түвшний зарим үзүүлэлтийг бодитой төлөвлөөгүй байна

ЦШСГ нь 2023-2024 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг сүүлийн 3 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл, болон тухайн оны худалдан авах цахилгааны хэмжээ, тариф, борлуулах цахилгааны хэмжээ, урьд онуудын худалдаж авсан, борлуулсан кВт/цаг цахилгааны хэмжээ, тайлант онд нэмэгдсэн цахилгаан хэрэглэгчдийн тоог үндэслэж төлөвлөж ажилласан байна.

ЭХЗХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 634, 636, 638 дугаар тогтоолоор Баруун бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон цахилгаан эрчим хүч хэрэглэгч үйлдвэр, ААНБ болон айл, өрхөд борлуулах цахилгааны тариф, цахилгааны чадлын тариф (индексжүүлж) болон нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг, баталж, 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдсөн байна.Цахилгаан эрчим хүчний худалдан авалт, түгээлтийн төлөвлөлт нь дараах байдалтай байна.

Хүснэгт №01 ЦШСГ-ын 2023-2024 оны зорилтот түвшний төлөвлөлт

А. Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022		2023	Өөрчлөлт	2023		2024	Өөрчлөлт
		Төлөв	Гүйцэтгэл	ТЗЭ-ийн санал / ЦШСГ/		Төлөв	Гүйцэтгэл	ТЗЭ-ийн санал / ЦШСГ/	
Худ.авах цахилгаан	мян.квт.цаг	54,156.0	73,486.0	78,350.0	4,864.0	78,350.0	75,362.0	81,400.1	6,038.10
Түгээлт алдагдал	мян.квт.цаг	8,595.0	12,188.0	12,657.0	469.0	12,657.0	12,271.0	12,999.9	728.90
Түгээлт алдагдал	хувь	15.9	16.6	16.2	(0.4)	16.2	16.3	16.0	(0.31)
Борлуулах цахилгаан	мян.квт.цаг	45,561.0	61,298.0	65,693.0	4,395.0	65,693.0	63,091.0	68,400.2	5,309.20
Борлуулалтын орлого	сая.төг	7,021.7	9,150.9	11,427.8	2,276.9	10,964.6	10,689.9	11,808.2	1,118.30
Борл. дундаж үнэ	төг.квт.цаг	154.11	149.29	173.95	24.7	166.91	169.44	172.63	3.19

Б. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022		2023	Өөрчлөлт	2023		2024	Өөрчлөлт
		Төл	Гүй	ТЗЭ-ийн санал / ЦШСГ/		Төл	Гүй	ТЗЭ-ийн санал / ЦШСГ/	
Худ.авах цахилгаан	мян.квт.цаг	54,156.0	73,486.0	78,350.0	24,194.0	78,350.0	75,362.0	81,400.1	3,050.1
Нийт орлого	**сая.төг**	**9,780.5**	**11,514.0**	**16,046.2**	**6,265.7**	**14,676.1**	**14,687.5**	**16,831.9**	**2,155.8**
Борлуулалтын орлого	сая.төг	7,021.7	9,150.9	11,427.8	4,406.1	10,964.6	10,689.9	11,808.2	843.6
Түгээх үйлч орлого	сая.төг	2,479.1	2,210.4	4,507.3	2,028.2	3,711.5	3,711.5	5,023.7	1,312.2
ҮА-ны бус орлого	сая.төг	279.7	152.7	111.1	(168.6)		286.1		-
Нийт зардал	**сая.төг**	**9,500.9**	**12,219.2**	**15,935.1**	**6,434.2**	**14,676.1**	**14,435.1**	**16,831.9**	**2,155.8**
Тарифт зардал-БОХШ	сая.төг	2,754.6	3,725.7	5,008.2	2,253.6	4,123.9	4,285.3	5,581.9	1,458.0
ХАЦ-ны өртөг /1*7/	сая.төг	6,746.3	8,493.5	10,926.9	4,180.6	10,552.2	10,149.8	11,250.0	697.8
Баланс, ашиг, алд	сая.төг	279.6	(705.2)	111.1	(168.5)	-	252.4	-	-
Орлогын албан татвар	сая.төг				-				-
Татварын дараах, ашиг ал	сая.төг	279.6		111.1	(168.5)				-
ХАЦ-ын тариф	төг.квт.цаг	124.57	115.58	139.46	14.9	134.68	134.68	138.21	3.5
Түгээх үйлчилгээний төлб	мян.төг.сар	206,591.7	184,200.0	375,612.3	169,020.6	309,293.6	309,291.7	418,644.7	109,351.1

Эх сурвалж: "ЦШСГ"- ОНӨААТҮГ-ын 2023-2024 оны бизнес төлөвлөгөө

"ББЭХ-ний систем" ХХК-аас 2023 онд 78.35 сая кВт/цаг, 2024 онд 81.40 сая квт/цаг цахилгаан худалдаж авахаар төлөвлөсөн байна. Үүнээс түгээлтийн алдагдлыг хасаж тооцоход 2023 онд 65.69 сая кВт/цаг, 2024 онд 68.40 сая кВт/цагийн цахилгаан борлуулахаар төлөвлөжээ.

Борлуулах цахилгааны хэмжээг 2023 онд өмнөх оноос 4.39 сая кВт/цаг, 2024 онд 5.30 сая кВт/цагаар нэмэгдүүлэн, цахилгаан түгээлтийн алдагдлын түвшинг өмнөх оноос 2023 онд 0.40%-иар 2024 онд 0.31 %-иар бууруулахаар төлөвлөжээ.

Үйл ажиллагааны орлого, зардалтай холбоотой төлөвлөлт дараах байдалтай байна.Үүнд:

ЦШСГ нь 2023 онд нийтдээ 16,046.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 15,935.1 сая төгрөгийн зардал гаргаж 111.1 сая төгрөгөөр ашигтай ажиллахаар, 2024 онд нийтдээ 14,687.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 14,687.5 сая төгрөгийн зардал гаргаж ашиг, алдагдлыг тэг байхаар төлөвлөжээ.

Нийт орлогын төлөвлөгөөг 2023 онд өмнөх оны гүйцэтгэлээс 39.4%-иар буюу 6,265.7 сая төгрөгөөр, 2024 онд 14.6%-иар буюу 2,155.8 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн ба борлуулалтын орлогыг 2023 онд 24.9%-иар буюу 4,406.1 сая төгрөгөөр 2024 онд 10.5%-иар буюу 843.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөжээ.

Үйл ажиллагааны бус орлогыг 2023 онд өмнөх оноос 27.2%-иар буюу 111.1 сая төгрөгөөр бууруулж, 2024 онд төлөвлөөгүй байна.

Нийт зардлыг 2023 онд өмнөх оноос 30.4%-иар буюу 6,434.2 сая төгрөгөөр, 2024 онд 16.6%-иар буюу 2,155.8 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна. Үүнээс үйл ажиллагааны зардал (тарифт зардал)-ыг 2023 онд 34.4%-иар буюу 2,253.6 сая төгрөг, 2024 онд 30.3%-иар буюу 1,458.0 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна.

Тарифт зардлын ихэнх хувийг эзэлдэг цалингийн зардлыг 2023 онд 828.9 сая төгрөгөөр буюу 53.8%-иар, НДШ-ийн зардлыг 106.2 сая төгрөгөөр буюу 44.7%-иар, 2024 онд 719.6 сая төгрөг буюу 36.8%-иар, НДШ-ийн зардлыг 98.6 сая төгрөгөөр буюу 34.1%-иар нэмэгдүүлж тооцсон байна.Бусад зардлуудыг өмнөх жилүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.

Илрүүлэлт:

- ЭХЗХ-д бизнес төлөвлөгөөг хянуулахдаа 2023 оны цалингийн санг 22%-иар буюу 425.6 сая төгрөгөөр, 2024 оны цалингийн санг 25%-иар буюу 536.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж санал өгсөн нь төлөвлөлт алдаатай байгааг харуулж байна. Цалингийн зардалтай холбоотой НДШ-ийн зардлыг мөн нэмж төлөвлөсөн байна.

- 2023 оны төлөвлөгөөнд ашиглалтын зардал буюу цахилгаан, цэвэр, бохир усны зардлыг төлөвлөөгүй байна.

- Алтай таван богд, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар застав чиглэлийн тендерийн орлого, зардлыг төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Байгууллагын үйл ажиллагааны орлого, зардлыг үндэслэлтэй төлөвлөж ажиллахыг зөвлөмж болгов.

"Суат" ХХК нь үйл ажиллагаа болон бизнес, эдийн засгийн төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулан боловсруулж ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан байна.

Хүснэгт №02 Бизнес, эдийн засгийн 2022 оны төлөвлөгөөг суурь болгож 2023-2024 оныг харьцуулсан судалгаа /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө				
	2022 он	2023 он	Хувь	2024 он	Хувь
Худалдаа үйлчилгээний байгууллага /ААН/	273,9	328,7	20.02	473,8	44.13
Төсөвт байгууллага	482,9	503,2	4.20	880,7	75.03
Орон сууц, гэр хороолол /Айл өрх/	332,1	413,8	24.59	600,7	45.16
Халуун ус /Түрээс/	168,8	190,9	13.04	226,3	18.55
Бусад борлуулалтын орлого/	65,4	81,3	24.29	70,5	-13.28
Орлогын дүн	**1,323,3**	**1,517,9**	**14.71**	**2,252,0**	**48.36**
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,235,8	1,383,6	11.96	1,781,1	28.73
Ерөнхий ба удирдлагын зардал	233,8	271,5	16.12	404,3	48.88
Зардлын дүн	**1,469,6**	**1,655,1**	**12.62**	**2,185,4**	**32.04**
Ашиг, алдагдал	(146,6)	(137,2)		66,6	

Эх сурвалж:" Суат" ХХК-ны санхүүгийн тайлан

"Суат" ХХК нь 2023 онд 1,518.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,655.1 сая төгрөгийн зардал гаргаж, 137.2 сая төгрөгийн алдагдалтай байхаар, 2024 онд 2,252.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,185.4 сая төгрөгийн зардал гаргаж, 66.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Орлогыг 2023 онд өмнөх оноос 194.7 сая төгрөгөөр буюу 14.7 хувиар, зардлыг 185.5 сая төгрөгөөр буюу 12.6 хувиар нэмэгдүүлэн төлөвлөжээ. Нийт орлогын өсөлт нь зарлагын өсөлтөөс 2.1 хувиар их байхаар тооцсон боловч

борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 11.9 хувиар, ерөнхий ба удирдлагын зардлыг 16.1 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

2024 онд орлогыг өмнөх оноос 734.0 сая төгрөгөөр буюу 48.4 хувиар, зардлыг 530.0 сая төгрөгөөр буюу 32 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн. Нийт орлогын өсөлт нь зардлын өсөлтөөс 16.3 хувиар их байхаар тооцож, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 28.7 хувиар, ерөнхий ба удирдлагын зардлыг 48.9 хувиар нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Хүснэгт №03 Өмнөх оны гүйцэтгэлтэй тухай жилийн төлөвлөгөө уялдсан эсэх талаарх судалгаа */сая төгрөг/*

Үзүүлэлт	2022 он	2023 он			2024 он	
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Хувь	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Хувь
	1	2	3=2/1	4	6	7=6-4
Худалдаа үйлчилгээний байгууллага /ААНэгж/	273,3	328,7	20.3	329,0	473,8	44.00
Төсөвт байгууллага	490,6	503,1	2.6	552,3	880,7	59.46
Орон сууц, гэр хороолол /Айл өрх/	345,8	413,8	19.7	477,2	600,7	25.87
Халуун ус /Түрээс/	180,2	190,9	5.9	230,2	226,3	(1.68)
Бусад борлуулалтын орлого/	54,2	81,3	50.1	80,0	70,5	(11.92)
Орлогын дүн	**1,344,1**	**1,517,9**	**12.9**	**1,668,8**	**2,252,1**	**34.95**
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,293,5	1,383,6	7.0	1,488,5	1,781,1	19.66
Ерөнхий ба удирдлагын зардал	244,2	271,5	11.2	271,9	404,3	48.69
Зардлын дүн	**1,537,6**	**1,655,1**	**7.6**	**1,760,4**	**2,185,4**	**24.14**
Ашиг, алдагдал	***-193,5***	***(137,2)***		***(91,6)***	***66,6***	

Эх сурвалж: Суат ХХК-ны санхүүгийн тайлан

Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2023 онд орлогыг 12.9 хувиар, зардлыг 7.6 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн бол 2024 онд орлогыг 34.9 хувиар, зардлыг 24.1 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Орлогыг нэмэгдүүлж төлөвлөсөн нь 2023 оны 08 дугаар сарын 01-нээс төсөвт байгууллагуудаас бусад хэрэглэгчдийн, 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс төсөвт байгууллагын усны үнэ тариф нэмэгдсэн, мөн шинэ хэрэглэгч нэмэгдсэнтэй холбоотой байна.

Ерөнхий ба удирдлагын зардлыг 2023 онд 11.2 хувиар, 2024 онд 48.7 хувиар өсгөж төлөвлөсөн нь борлуулсан бүтээгдэхүүний өртгийн өсөлтөөс 4.2-29.0 хувиар өндөр байна.

Компанийн орлого, зардлыг үндэслэлтэй төлөвлөж, батлуулахыг зөвлөмж болгов.

1.1.3. ЦШСГ-ын зорилтот түвшний зарим үзүүлэлтийг бодитой хянаагүй байна

ЦШСГ-ын 2023-2024 оны бизнес, санхүүгийн төлөвлөгөөг ЭХЗХ-ын Үнэ тарифын газарт хянуулж ажилласан байна. Эдийн засгийн зорилтот түвшнийг дараах байдлаар хянаж ирүүлсэн байна.

Хүснэгт №04 ҮТГ-аас ЦШСГ-ын 2023-2024 оны төлөвлөлтийг хянасан байдал

А. Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2023		Өөрч-т	2024		Өөрч-т
	Хэмжэх нэгж	ТЗЭ-ийн санал	ҮТГ-аас хянасан		ТЗЭ-ийн санал	ҮТГ-аас хянасан	
Худ.авах цахилгаан	мян.квт.цаг	78,350.0	78,350.0	-	81,400.1	81,400.1	-
Түгээлт алдагдал	мян.квт.цаг	12,657.0	12,657.0	-	12,999.9	12,999.9	-
Түгээлт алдагдал	хувь	16.2	16.2	-	16.0	16.0	-
Борлуулах цахилгаан	мян.квт.цаг	65,693.0	65,693.0	-	68,400.2	68,400.2	-
Борлуулалтын орлого	сая.төг	11,427.8	10,964.6	463.2	11,808.2	11,808.2	-
Борл. дундаж үнэ	төг.квт.цаг	173.95	166.90	7.0	172.63	172.63	-

Б. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2023		Өөрч-т	2024		Өөрч-т
	Хэмжэх нэгж	ТЗЭ-ийн санал	ҮТГ-аас хянасан		ТЗЭ-ийн санал	ҮТГ-аас хянасан	
Худ.авах цахилгаан	мян.квт.цаг	78,350.0	78,350.0	-	81,400.1	81,400.1	-
Нийт орлого	сая.төг	16,046.2	14,787.8	(1,258.4)	16,831.9	16,536.9	(295.0)
Борлуулалтын орлого	сая.төг	11,427.8	10,964.6	(463.2)	11,808.2	11,808.2	-
Түгээх үйлч орлого	сая.төг	4,507.3	3,711.5	(795.8)	5,023.7	4,613.9	(409.8)
ҮА-ны бус орлого	сая.төг	111.1	111.7	0.6		114.8	114.8
Нийт зардал	сая.төг	15,935.1	14,676.1	(1,259.0)	16,831.9	16,422.1	(409.8)
Тарифт зардал-БОХШ	сая.төг	5,008.2	4,123.9	(884.3)	5,581.9	5,126.6	(455.3)
ХАЦ-ны өртөг /1*7/	сая.төг	10,926.9	10,552.2	(374.7)	11,250.0	11,295.5	45.5
Баланс, ашиг, алд	сая.төг	111.1	111.7	0.6	-	114.8	114.8
ХАЦ-ын тариф	төг.квт.цаг	139.46	134.68	(4.8)	138.21	138.77	0.6
Түгээх үйлчилгээний төлбөр	мян.төг.сар	375,612.3	309,293.6	(66,318.7)	418,644.7	384,492.5	(34,152.2)

Эх сурвалж: ЦШСГ- ын 2023-2024 оны техник, санхүү, эдийн засгийн үзүүлэлт

ЭХЗХ-ны ҮТГ-аас 2023 онд худалдан авах, борлуулах цахилгааны кВт/цагийг хэвээрээ баталж борлуулалтын орлогыг 463.2 сая төгрөгөөр (дундаж үнийг 7 төгрөгөөр) бууруулж, 2024 онд худалдан авах, борлуулах цахилгаан болон борлуулалтын орлогын хэмжээг хэвээр нь баталсан байна.

ЦШСГ-ын 2023 оны нийт орлогын төлөвлөгөөг 1,258.4 сая төгрөгөөр, үүнээс борлуулалтын орлогыг 463.2 сая төгрөгөөр, түгээх үйлчилгээний орлогыг 795.8 сая төгрөгөөр бууруулж, үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

2024 оны нийт орлогыг 295.0 сая төгрөгөөр бууруулж, үүнээс түгээх үйлчилгээний орлогыг 409.8 сая төгрөгөөр бууруулж, үндсэн үйл ажиллагааны орлогыг 114.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Тус газрын 2023 оны нийт зардлыг 1,259.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.Үүнээс: тарифт зардал буюу нийт үйл ажиллагааны зардлыг 884.3 сая төгрөгөөр, ХАЦ-ний өртгийг 374.7 сая төгрөгөөр бууруулж 0.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар, 2024 оны зардлыг 409.8 сая төгрөгөөр, үүнээс тарифт зардлыг 455.3 сая төгрөгөөр бууруулж, ХАЦ-ны өртгийг 45.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 114.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар хянасан байна.

Илрүүлэлт:

Удирдах зөвлөл нь ЦШСГ-ын 2023 оны бизнес төлөвлөгөөг баталсан боловч техник, эдийн засгийн үзүүлэлт бүрээр хянаж батлаагүй, харин 2024 оны бизнес, санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэж батлаагүй, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Бизнес төлөвлөгөөг хүрэх түвшнийг эдийн засгийн үзүүлэлт тус бүрээр ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар батлуулж ажиллахыг зөвлөмж болгов.

“Суат” ХХК-ны 2023 оны үйл ажиллагааны болон санхүү, бизнес эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор, 2024 оны үйл ажиллагааны болон санхүү, бизнес эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор тус тус баталсан.

“Суат” ХХК-ны 2024 оны үйл ажиллагааны тайланг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдийн 18 дүгээр албан бичгээр, бизнес, эдийн засгийн тайланг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлж, хэлэлцүүлсэн байна.

Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний зохицуулах хороонд компанийн үйл ажиллагаа болон бизнес, зэдийн засгийн төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнаж ажилласан байна.

1.2. ОНӨААН-ҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР ДҮНТЭЙ, ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАСАН БАЙНА

1.2.1. Үйл ажиллагааны зорилтот түвшнийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна

ЦШСГ-ын эдийн засгийн үзүүлэлтүүдийн биелэлтийн талаар:

Хүснэгт №05 ЦШСГ-ын 2023-2024 оны зорилтот түвшний биелэлтийн судалгаа

А. Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжэх нэгж	2023		Өөрчлөлт		2024		Өөрчлөлт	
			Төл	Гүйц	Биет	Хувь	Төл	Гүйц	Биет	Хувь
1	Худ.авах цахилгаан	мян.квт.цаг	78,350.0	75,362.0	(2,988.0)	96.2	81,400.1	85,866.1	4,466.0	105.5
2	Түгээлт алдагдал	мян.квт.цаг	12,657.0	12,271.0	(386.0)	97.0	12,999.9	13,729.0	729.1	105.6
	Түгээлт алдагдал	хувь	16.2	16.3	0.1	100.8	16.0	16.0	0.0	100.1
3	Борлуулах цахилгаан	мян.квт.цаг	65,693.0	63,091.0	(2,602.0)	96.0	68,400.2	72,137.1	3,736.9	105.5
4	Борлуулалтын орлого	сая.төг	10,964.6	10,689.9	(274.7)	97.5	11,808.2	12,769.2	961.0	108.1
5	Борл. дундаж үнэ	төг.квт.цаг	166.91	169.44	2.5	101.5	172.63	177.01	4.4	102.5

Б. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжэх нэгж	2023		Өөрчлөлт		2024		Өөрчлөлт	
			Төл	Гүйц	Биет	Хувь	Төл	Гүйц	Биет	Хувь
1	Худ.авах цахилгаан	мян.квт.цаг	78,350.0	75,362.0	(2,988.0)	96.2	81,400.1	85,866.1	4,466.0	105.5
2	**Нийт орлого**	сая.төг	**14,787.2**	**14,687.5**	(99.7)	99.3	**16,536.9**	**17,830.7**	1,293.8	107.8
	Борлуулалтын орлого	сая.төг	10,964.0	10,689.9	(274.1)	97.5	11,808.2	12,769.2	961.0	108.1
	Түгээх үйлч орлого	сая.төг	3,711.5	3,711.5	-	100.0	4,613.9	4,613.9	(0.0)	100.0
	ҮА-ны бус орлого	сая.төг	111.7	286.1	174.4	256.1	114.8	447.6	332.8	389.9
3	**Нийт зардал**	сая.төг	**14,675.5**	**14,435.1**	(240.4)	98.4	**16,422.1**	**17,672.2**	1,250.1	107.6
	Тарифт зардал-БОХШ	сая.төг	4,123.3	4,285.3	162.0	103.9	5,126.6	5,148.9	22.3	100.4
	ХАЦ-ны өртөг /1*7/	сая.төг	10,552.2	10,149.8	(402.4)	96.2	11,295.5	12,523.3	1,227.8	110.9
4	**Баланс, ашиг, алд**	сая.төг	111.7	252.4	140.7	226.0	114.8	158.5	43.7	138.1
5	Орлогын албан татвар	сая.төг		25.2	25.2			15.8	15.8	
6	**Татварын дараах ашиг, алдагдал**	сая.төг		227.2	227.2			142.7	142.7	
7	ХАЦ-ын тариф	төг.квт.цаг	134.68	134.68	0.0	100.0	138.77	145.85	7.1	105.1
8	Түгээх үйлчилгээ төлбөр	мян.төг.сар	309,293.6	309,291.7	(1.9)	100.0	384,492.5	384,492.5	(0.0)	100.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

“ББЭХС” ТӨХК -аас 2023 онд 75.36 сая.квт/цаг цахилгаан эрчим хүч худалдаж авсан нь төлөвлөснөөс 2.9 сая.квт/цаг буюу 3.8 хувиар бага, 2024 онд 85.86 сая.квт/цаг цахилгаан эрчим хүч худалдаж авсан нь төлөвлөснөөс 4.4 сая.квт/цаг буюу 5.5 хувиар их байна.

Эрчим хүчний хэрэглээ 2023 онд буурсан нь “Дулаан хар Юшенг-Минг” ХХК, “Файнноос” ХХК, зам гүүрийн “Лунзяанроуд” ХХК зэрэг томоохон компаниудын үйл ажиллагаа нь зогссонтой холбоотой байна.

Түгээлтийн алдагдлыг 2023-2024 онд тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй ажиллах зорилт тавьж 2023 онд 16.3%-ийн алдагдалтай ажиллаж төлөвлөснөөс 0.1 нэгжээр хэтэрсэн өссөн бол 2024 онд алдагдлыг төлөвлөсөн хэмжээнд барьж ажилласан байна.

Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр 2023 онд Өлгийн сумын төвийн АТП, СИП солих, дэд станцуудын щит самбарыг өргөтгөх, солих, хуучин тоноглолуудыг сэргээн засварлах, кабель шинэчлэх, ухаалаг тоолуур тавих, айл, өрхийн хайрцгийн газардуулгыг шинэчлэх зэрэг их засвар, хөрөнгө оруулалтын 410.6 сая төгрөгийн 20 ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн байна.

Айл, өрхийн хэрэглэгчдийн 576 ш ухаалаг тоолуурыг тоолуурын системд шилжүүлснээр дэд станцуудын түгээлтийн алдагдал 1.5 хувиар буурсан, ААНБ болон хэрэглэгчийн ашиглаж буй стандарт бус гүйдлийн трансформаторыг шалгаж 56 ширхэг гүйдлийн трансформаторыг сольж тавьсан байна.

Түгээлтийн алдагдлыг бууруулах ажлын хүрээнд 2024 онд их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын 899.3 сая төгрөгийн 32 ажлыг хийхээр төлөвлөж, 806.63 сая төгрөгийн 29 ажил буюу 90.5 хувьтай гүйцэтгэж, аймгийн төвийн 1500 хэрэглэгчийг ухаалаг тоолуурын системд шилжүүлэх ажил хийгдсэн байна. Үүнээс 500 ш тоолуурыг өөрийн хөрөнгөөр, 1000 ш тоолуурыг аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийсэн байна.

Аймгийн төвийн 0.4кВ-ын хуучирсан 2 дэд өртөөний СИП кабелийг сольж шинэчлэх ажил, хуучирсан АС шугамуудыг солих ажил хийгдсэнээр[1] алдагдал төлөвлөсөн хэмжээнд буюу 16.0%-тай гарсан байна.

ЦШСГ-ын нийт орлого гүйцэтгэлээр 2023 онд 99.7 сая төгрөг буюу 0.3 %-иар буурсан бол 2024 онд 1,293.8 сая төгрөг буюу 7.8%-иар өссөн байна. Үүнээс:

Борлуулалтын орлого 2023 онд 274.1 сая төгрөгөөр буюу 2.5%-иар буурч, 2024 онд 961.0 сая төгрөгөөр буюу 8.1 %-иар өссөн байна.

Түгээлтийн үйлчилгээний орлого 2023-2024 онд 100%-ийн биелэлттэй байна.Үйл ажиллагааны бус орлого 2023 онд 177.4 сая төгрөгөөр буюу 1.5 дахин, 2024 онд 332.8 сая төгрөгөөр буюу 2.9 дахин өссөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2023 онд 240.4 сая төгрөгөөр буюу 1.6%-иар хэмнэлттэй, 2024 онд 1,250.1 сая төгрөгөөр буюу 7.6%-иар хэтрэлттэй гарсан байна.

2023 онд үйл ажиллагааны зардал (тарифт зардал-БОХШ) 162.0 сая төгрөгөөр буюу 3.9%-иар хэтэрч, ХАЦ-ний өртөг 402.4 сая төгрөг буюу 3.8%-иар хэмнэлттэй гарсан байна.

2024 онд үйл ажиллагааны зардал 22.3 сая төгрөг буюу 0.4%-иар, ХАЦ-ний өртөг 1,227.8 сая төгрөгөөр буюу 10.9 %-иар хэтэрсэн байна. Цахилгааны үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой ХАЦ-ний өртөг 2024 онд нэмэгдсэн байна.

Тус газрын 2023-2024 оны нийт зардлыг бүтцээр нь авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №06 ЦШСГ-ын 2023-2024 оны зардлын бүтцийн судалгаа сая. төг

[5] *" БӨ аймгийн ЦШСГ" ОНӨААТҮГ-ын цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын 2023 оны зорилтын биелэлтийг дүгнэх, 2024 оны шаардлагын тогтоох тухай " ЭХЗХ-ны 2024 оны тайлан*

Үзүүлэлт	2023		Өөрчлөлт		2024		Өөрчлөлт	
	төл	гүйц	Биет	Хувь	төл	гүйц	Биет	Хувь
Цалин, НДШ	2,224.8	2,247.4	22.6	101.0	2,765.5	2,763.9	(1.7)	99.9
Элэгдлийн зардал	876.0	1,025.1	149.1	117.0	889.3	1,092.2	202.9	122.8
бусад зардал	1,022.5	1,012.8	(9.7)	99.1	1,471.7	1,292.8	(178.9)	87.8
Нийт зардал	**4,123.3**	**4,285.3**	162.0	**103.9**	**5,126.6**	**5,148.9**	**22.3**	**100.4**

Эх сурвалж: Аудитын судалгаа

Цалин, НДШ-ийн зардал 2023 онд 22.6 сая төгрөг буюу 0.1%-иар, элэгдлийн зардал 149.1 сая төгрөгөөр буюу 17%-иар хэтэрсэн, 2024 онд цалин, НДШ-ийн зардал 1.7 сая төгрөг буюу 0.1%-иар хэмнэгдэж, элэгдлийн зардал 202.9 сая төгрөг буюу 22.8%-иар хэтэрсэн байна.

Нийт зардлын 52-54%-ийг цалин, урамшуулал, НДШ-ийн зардал, 21-24%-ийг элэгдлийн зардал, 24-25%-ийг бусад зардал тус тус эзэлж байна.

ЦШСГ нь 2023 онд 227.2 сая төгрөгийн, 2024 онд 142.7 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласнаар тайлагнасан боловч 2024 онд “Мэйжүрмент” ХХК-аас нийлүүлсэн 198.0 сая төгрөгийн үнийн дүнтэй ухаалаг тоолуурыг бусад орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Авлага, богино хугацаат өр төлбөрийг судалж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №07 ЦШСГ-ын 2023-2024 оны авлагын судалгаа */сая.төг/*

Авлага	2022	2023	Өөрчлөлт		2023	2024	Өөрчлөлт	
			Биет	Хувь			Биет	Хувь
Орон сууц	20.3	25.9	5.6	127.6	25.9	26.7	0.8	103.1
Гэр хороолол	373.8	631.7	257.9	169.0	631.7	911.4	279.7	144.3
ААНБ	1,106.5	762.0	(344.5)	68.9	762.0	1,120.3	358.3	147.0
Төсөв	66.3	142.2	75.9	214.5	142.2	103.5	(38.7)	72.8
Бусад	431.0	220.5	(210.5)	51.2	220.5	282.7	62.2	128.2
Нийт	**1,997.9**	**1,782.3**	**(215.6)**	**89.2**	**1,782.3**	**2,444.6**	**662.3**	**137.2**

Эх сурвалж: ЦШСГ-ын 2023-2024 оны, ЭХЗХ-ын 2023-2024 оны тайлан

Нийт авлага 2023 онд 215.6 сая төгрөг буюу өмнөх оноос 10.8%-иар буурсан бол 2024 онд 662.3 сая төгрөг буюу 37.2%-иар нэмэгдсэн байна. Үүнд: Гэр хорооллын авлага 279.7 сая төгрөгөөр, ААНБ-ийн авлага 358.3 сая төгрөгөөр, бусад авлага 62.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлага өсөхөд нөлөөлсөн байна.

Хүснэгт №08 ЦШСГ-ын 2023-2024 оны БХӨТ-ийн судалгаа */сая.төг/*

БХӨТ	2022	2023	Өөрчлөлт		2023	2024	Өөрчлөлт	
			Биет	Хувь			Биет	Хувь
Татварт	0.5	0.5	-	100.0	0.5	3.7	3.2	740.0
Бусад	157.5	878.0	720.5	557.5	878.0	1,388.1	510.1	158.1
Нийт	**158.0**	**878.5**	**720.5**	**556.0**	**878.5**	**1,391.8**	**513.3**	**158.4**

Эх сурвалж: ЦШСГ-ын 2023-2024 оны аудитлагдсан ЭХЗХ-ын 2023-2024 оны тайлан

БХӨТ нь 2023 онд өмнөх оноос 720.5 сая төгрөгөөр буюу 5.5 дахин нэмэгдсэн бол 2024 онд 513.3 сая төгрөгөөр буюу 58.4%-иар нэмэгдсэн байна.

"Суат" ХХК-нийн эдийн засгийн үзүүлэлтүүдийн биелэлтийн талаар:

Хүснэгт №09 "Суат" ХХК-ний үйл ажиллагааны орлого, зардлын төлөвлөлт, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	2023 он				2024 он			
	Төлөвлөгөө	**Гүйцэтгэл**	**Зөрүү**	**Хувь**	**Төлөвлөгөө**	**Гүйцэтгэл**	**Зөрүү**	**Хувь**
Худалдаа үйлчилгээний байгууллага /ААНэгж/	328,7	329,0	0,3	100.1	473,8	465,6	(8,2)	98.3
Төсөвт байгууллага	503,2	552,3	49,1	109.8	880,7	836,9	(43,7)	95.0
Орон сууц, гэр хороолол /Айл өрх/	413,8	477,3	63,4	115.3	600,7	656,2	55,4	109.2
Халуун ус /Түрээс/	190,9	230,2	39,3	120.6	226,3	296,1	69,9	130.8
Бусад борлуулалтын орлого/	81,3	80,0	(1,2)	98.5	70,5	84,9	14,4	120.5
Орлогын дүн	**1,517,9**	**1,668,8**	**150,8**	**109.9**	**2,252,1**	**2,339,8**	**87,7**	**103.9**
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,383,6	1,488,5	(104,9)	107.6	1,781,1	1,770,0	11,1	99.4
Ерөнхий ба удирдлагын зардал	271,5	271,8	(0,4)	100.1	404,3	359,0	45,2	88.8
Зардлын дүн	**1,655,1**	**1,760,4**	**(105,,3)**	106.4	**2,185,4**	**2,129,1**	**56,3**	97.4
Ашиг, алдагдал	***(137,2)***	***(91,6)***	***45,6***		***66,6***	***210,7***	***144,1***	

Эх сурвалж: Суат ХХК-ний санхүүгийн тайлан

"Суат" ХХК нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,668.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,760.4 сая төгрөгийн зардал гаргаж, 91.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Төлөвлөснөөс орлого 150.8 сая төгрөгөөр өссөн боловч зардал нь 105.3 сая төгрөгөөр хэтэрч, алдагдал нь төлөвлөсөн хэмжээнээс 45.5 сая төгрөгөөр буурсан байна.

2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 2,339.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,129.1 сая төгрөгийн зардал гаргаж, 210.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлого нь төлөвлөснөөс 87.7 сая төгрөгөөр өсөж, зардлыг 56.3 сая төгрөгөөр хэмнэж, төлөвлөсөн ашгийн хэмжээ 144.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орлого нэмэгдэхэд цэвэр, бохир усны шугамд холбогдсон хэрэглэгчийн тоо нэмэгдэж, үнэ тариф өссөн нь орлого өсөхөд нөлөөлсөн байна. Тухайлбал: 2023 онд 18 төсвийн байгууллага, 31 аж ахуйн нэгж, 181 айл, өрх шинээр холбогдсон бол 2024 онд 14 аж ахуйн нэгж, 242 айл, өрх шинээр холбогджээ.

Аймгийн төвийн төвлөрсөн шугамд холбогдсон 78 төсөвт байгууллагын 53.8 хувь буюу 42 нь тоолууртай ба 46.2 хувь буюу 36 нь тоолуургүй байна. Нийт 78 байгууллагаас 37 байгууллагын хэрэглэсэн цэвэр, бохир усны тооцоог тоолууруар авч байгаа боловч 41 байгууллагын төлбөрийн тооцоог тогтмол буюу тухайн байгууллагын цэвэр, бохир усны батлагдсан төсвийн хэмжээгээр тооцож авдаг байна.

Энэхүү байгууллагуудын цэвэр, бохир усны төлбөрийг тоолуураар тооцохгүй байгаа нь тухайн байгууллагуудын цэвэр, бохир усны батлагдсан төсөв хүрэлцдэггүйтэй холбоотой байна. Тоолуур тавихгүйгээр техникийн нөхцөл олгож, хэрэглэгчийг шугамд холбосон зөрчлүүд илэрсэн нь "Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 2.5.3-т заасан "Хэмжих хэрэгслийн зангилаа, тоног төхөөрөмж нь батлагдсан зураг, схемийн дагуу угсрагдсан, баталгаажуулсан тоолуур суурилуулсан байх", 3.2, 311-т заасан заалтуудыг зөрчиж байна.

"Суат" ХХК-аас зарим томоохон төсөвт байгууллагуудын цэвэр, бохир усны төсвийг бодит хэрэглээтэй харьцуулж судалгаа хийсэн байна. Үүнд:

- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны эхний 10 сарын цэвэр бохир усны төлбөрийг тоолуурын аргаар тооцож үзэхэд 483.8 сая төгрөгийн төлбөр гарч, батлагдсан төсвөөс 233.8 сая төгрөгөөр илүү гарсан,
- Өлгий сумын 2 дугаар сургуулийн хүсэлтээр 2023 оны цэвэр бохир усны төлбөрийг тоолуураар тооцоход 61.7 сая төгрөгийн төлбөр гарч батлагдсан төсвөөс 15.8 сая төгрөгөөр илүү гарч авлагаар бүртгэж ажилласан байна.

Энэ нь төсөвт байгууллагуудын цэвэр, бохир усны төлбөрийг тоолуурын заалтаар бус тухайн байгууллагуудын батлагдсан төсвөөр тооцож авч байгаа нь ихээхэн хэмжээний орлого алдаж, усны алдагдал болж байгааг харуулж байна. Иймд төсөвт байгууллагуудын цэвэр, бохир усны төлбөрийг тоолуурын заалтаар авах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооноос хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар "Суат" ХХК-нд 2024, 2025 оны эхийн хагас жилийн байдлаар байгууллагын харилцах дансанд төлбөрт үйлчилгээ үзүүлсэн орлогыг төвлөрүүлээгүй байгаа нь байгууллагын дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.2.10, хэрэглэгчтэй байгуулсан "Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээний гэрээний 4 дүгээр зүйлийн 4.15-д заасныг зөрчиж байгаа тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Төсөвт байгууллагын усны төлбөрийг тоолуурын заалтаар авах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, төлбөрт үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

1.2.2 ЦШСГ нь бусад орлогыг үнэн зөв тайлагнаагүй, зарим орлогыг дутуу төвлөрүүлсэн байна

<u>ЦШСГ-ын орлого бүрдүүлэлт, тайлагналын талаар:</u> Тус газрын нийт орлогын гүйцэтгэл 2023 онд төлөвлөснөөс 99.7 сая төгрөгөөр буюу 0.7%-иар тасарч, 2024 онд 1,293.8 сая төгрөгөөр буюу 7.8%-иар давж биелэгдсэн байна.

Хүснэгт №10 ЦШСГ-ын 2023-2024 оны орлогын судалгаа /сая.төг/

Үзүүлэлт	2023		Өөрчлөлт		2024		Өөрчлөлт	
	төл	гүйц	Биет	Хувь	төл	гүйц	Биет	Хувь
Үйлдвэрлэлийн байгууллага	614.4	1,524.6	910.2	248.2	1,633.2	762.6	-870.6	46.7
Худалдаа үйчилгээний байгууллага	4,054.1	2,963.2	-1,090.9	73.1	3,720.6	4,126.1	405.5	110.9
Төсөвт байгууллага	1,033.1	1,115.6	82.5	108.0	1,105.9	1,521.8	415.9	137.6

Орон сууц	749.9	569.9	-180.0	76.0	597.6	722.0	124.3	120.8
Гэр хороолол	4,513.1	4,516.6	3.5	100.1	4,750.8	5,636.7	885.9	118.6
Түгээх үйлчилгээний орлого	3,711.5	3,711.5	0.0	100.0	4,613.9	4,613.9	0.0	100.0
Нийт орлого	**14,676.1**	**14,401.4**	-274.7	98.1	**16,422.1**	**17,383.1**	961.0	105.9
Хүүгийн	32.0	211.6	179.6	661.1	18.7	18.2	-0.5	97.4
Бусад орлого	79.1	74.6	-4.5	94.3	96.1	429.4	333.3	446.9
Нийт орлого	**14,787.2**	**14,687.5**	-99.7	99.3	**16,536.9**	**17,830.7**	1,293.8	107.8

Эх сурвалж: ЦШС-ний 2023-2024 оны бизнес, санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Айл, өрх, ААНБ болон түгээлтийн орлого 2023 онд 1.9%-иар буюу 274.1 сая төгрөгөөр тасарсан бол 2024 онд 5.9%-иар буюу 961.0 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Цахилгааны үнэ, тарифт өөрчлөлт орж, нэмэгдсэнтэй холбоотой айл, өрх, ААНБ-аас төвлөрүүлсэн орлого нэмэгдсэн байна.

Хүүгийн орлого 2023 онд 179.6 сая төгрөгөөр илүү, 2024 онд 0.5 сая төгрөгөөр дутуу биелэгдэж, бусад орлого 2023 онд 4.5 сая төгрөгөөр дутуу, 2024 онд 333.3 сая төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Илрүүлэлт:

- ЦШСГ-ын 2023 оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэгдэх ёстой 202.9 сая төгрөгийн алдангийг хүүгийн орлогоор тайлагнасан.

- 2024 оны санхүүгийн тайланд ОНТХО-ийн санхүүжилтээр "Мэйжүрмент" ХХК-ны нийлүүлсэн 198.0 сая төгрөгийн ухаалаг тоолуурыг бусад орлогоор тайлагнаснаас 142.7 сая төгрөгийн орлогыг илүү тайлагнасан.

- Үйл ажиллагааны бус орлогод хамаарах техникийн нөхцөлийн суурь хураамжийн орлогоос 2023 онд 10.5 сая төгрөг, 2024 онд 10.2 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.

- ЦШСГ-ын МҮОНРТ-тэй 2022.06.02-ны өдөр байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-нд телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг цахилгааны төлбөртэй хамт нэхэмжлэн авч, ЦШСГ-т 17%-ийн үйлчилгээний хөлс олгохоор тусгасан.Өлгий сумын Засаг даргатай 2023.01.03-ны өдөр байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-нд нийтийн орон сууцны оршин суугч иргэдийн хогны хураамжийг цахилгааны төлбөртэй хамт нэхэмжлэн авч, ЦШСГ-т орлогын 12%-ийг олгохоор тусгасан. Телевизийн болон хогны хураамжийн 2023-2024 оны орлогоос "Орда" СӨХ-ноос 5.9 сая төгрөг, МҮОНРТ-ээс телевизийн хураамжаас 1.5 сая төгрөгийг ЦШСГ-т дутуу төвлөрүүлж, авлагаар тайлагнаагүй байна.

Аудитын дүнгээр бусад орлогыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгахыг зөвлөмж болгож, телевизийн хураамжийн орлогоос дутуу төвлөрүүлсэн 1.5 сая төгрөг, хогны хураамжийн орлогоос дутуу төвлөрүүлсэн 5.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, техникийн нөхцөлийн суурь хураамжийн орлогоос дутуу төлүүлсэн 20.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов..

Алтай таван богдын байгалийн цогцолборт газар, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамжийн тендерийн ажлын тайлагнал, бүртгэл тооцооны талаар:

Орлого, зардлыг санхүүгийн тайланд тусгаагүй, тооцоог зохих журмаар хийгээгүй байна

ЦШСГ нь 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрчим хүчний сайдын багцаас санхүүжих хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамжаар хангах 4,499.9 сая төгрөгийн, Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамжаар хангах 2,399.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарч, түлхүүр гардуулах нөхцөлтэй аймгийн Засаг даргатай 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр ЭХЯ/202211021, ЭХЯ/202212012 дугаартай гэрээг байгуулсан байна.

Төслийн зураг төсвийг “Бодит хүчин чадал” ХХК гүйцэтгэж, магадлан экпертизд 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр батлуулж зураг, төсвийг 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр ЦШСГ-т хүлээлгэж өгсөн байна.

Магадлан экспертизээр хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамжаар хангах төслийн нийт төсөвт өртөг 5,535.8 сая төгрөг болж 1,035.8 сая төгрөгөөр, Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамжаар хангах төслийн нийт төсөвт өртөг 3,551.6 сая төгрөг болж 1,151.6 сая төгрөгөөр буюу нийт төсөвт өртөг нь 2,187.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

УИХ-аас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн найруулж баталсан ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4-т заасны дагуу 2024 онд нэмэлт санхүүжилтийн дүнгээр 2 багц тендер зарлаж БӨАОНӨГ/20240101120 багцыг “Өгөөж барс” ХХК, БӨАОНӨГ/20240101121 багцыг “Бүрэн холбоо констракшн” ХХК шалгаран гүйцэтгэж байгаа юм байна.

“Өгөөж барс” ХХК-ны гүйцэтгэх ажлын тоо хэмжээний зөрүү гарсан тул 270.7 сая төгрөгийг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр тооцоо нийлж, ЦШСГ-т буцаан авахаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

“Бүрэн холбоо констракшн” ХХК 2024 онд Алтай таван богд, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын чиглэлийн АС шугам татах гэрээг 380.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр байгуулан, Алтай таван богд чиглэлийн хэсгийн АС шугамыг татах ажлыг 2024 онд хийж дуусгасан байна.

“Бүрэн холбоо констракшн” ХХК-ны тендерээр гүйцэтгэхээр авсан ажлын дэд станц байгуулах ажлын зарим хэсгийг 2023 онд Цахилгаан шугам сүлжээний газар хийж дуусгасан байна. Харин “Бүрэн холбоо констракшн” ХХК-ны авлага, өглөгийг эцсийн байдлаар тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

ЦШСГ нь дээрх 2 төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлээр 2022 онд 227.2 сая төгрөгийн, 2023 онд 2,548.7 сая төгрөгийн, 2024 онд 1,539.0 сая төгрөгийн, нийтдээ 4,315.4 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2-р заставын цахилгаан хангамжаар хангах төсөл арга хэмжээний гүйцэтгэл 42.6 хувьтай, Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамжаар хангах төсөл арга хэмжээний гүйцэтгэл 53.3 хувьтай,

2024 оны жилийн эцсийн байдлаар хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2-р заставын цахилгаан хангамжаар хангах төсөл арга хэмжээний гүйцэтгэл 58.4

хувьтай, Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамжаар хангах төсөл арга хэмжээний гүйцэтгэл 89.0 хувьтай байна.

Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар застав, Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамжаар хангах төслийн 2023 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 595.7 сая төгрөг, 2024 оны жилийн эцсийн үлдэгдэл 603.1 сая төгрөг байна.

Хүснэгт №11 Төслийн орлого, зардлын судалгаа / сая төгрөгөөр/

Он	Эхний үлдэгдэл	Авсан санхүүжилт	үйл ажиллагааны орлогоос	Гарсан зарлага	Эцсийн үлдэгдэл
2022		227.2	43.7	250.1	20.8
2023	20.8	2,548.8		1,973.8	595.7
2024	595.7	1,539.0		1,531.6	603.2
Нийт дүн		**4,314.9**	**43.7**	**3,755.5**	

Эх сурвалж: ТАХ-ний орлого, зарцуулалтад хийсэн аудитын судалгаа

2022-2024 онд нийтдээ 4,314.9 сая төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 43.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,755.5 сая төгрөгийг зарцуулж, 2024 оны эцэст төслийн дансанд 603.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан. Төсөлтэй холбоотой худалдан авсан бараа материалын үлдэгдэл 2023 онд 220.6 сая төгрөг, 2024 оны үлдэгдэл 569.9 сая төгрөг байна.

***Аудитын дүнгээр төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд*:**

1. ЦШСГ нь 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Хятад улсад багана болон сэлбэг хэрэгслийн үнийг шилжүүлж эхэлсэн байна. 2022-2024 онд баганын үнэд нийтдээ 1,115.7 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Үүнээс “Проект Ватт” ХХК-д 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр 65.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба үлдсэн 1,050.7 сая төгрөгийг иргэн Алтанцэцэгийн дансанд шилжүүлсэн байна. Иргэн Алтанцэцэг нь Хятад улсын нийлүүлэгч компанид юанийг шилжүүлдэг байсан байна.

ЦШСГ-ын даргаар ажиллаж байсан Ж.Керей нь 2023 оны 07 дугаар сарын 14-ний өдөр Хятад улсын Шинжаан Бэйдиан /Нордиан/ Датун цахилгаан эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн ХХК-тай гэрээ байгуулсан ба гэрээнд нийт 1500 ширхэг баганыг нэг бүрийг нь 980 юанаар худалдан авахаар тохирсон байна. Гэрээнд худалдан авагч тал хилийн боомт хүртэлх тээврийн зардлыг хариуцахаар тусгасан боловч 1 ширхэг баганыг хэдэн юанаар тээвэрлэх талаар тодорхой тусгаагүй байна.

2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүртэл 1030 ширхэг багана гаалиар орж ирсэн бөгөөд санхүүгийн баримтад ямар нэгэн худалдах, худалдан авах гэрээ байхгүй байна.

Датун цахилгаан эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн ХХК-тай байгуулсан гэрээнд 1500 ширхэг багана худалдан авна гэсэн боловч 2023 оны 07 дугаар сарын 14-ний өдрөөс 2024 он хүртэл 633 багана гаалиар орж ирсэн байна.

Үүнээс үзэхэд гэрээ хийгээгүй байхад 1030 ш баганыг худалдан авч гаалиар оруулж ирсэн байна.

Тус газрын даргаар ажиллаж байсан Ж.Керей нь 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 800 ширхэг баганыг нэг бүрийг 320 юанаар, 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 700 баганыг 320 юанаар тээвэрлэх, нийлүүлэлтийн хоёр гэрээг Су Кэ гэсэн иргэнтэй байгуулж, Чинхэ боомт хүртэл тээвэрлэх гэрээ ирүүлсэн.

Гэтэл 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл 1001 ширхэг баганыг тээвэрлэж дууссан байна. Мөн 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл нийт 662 ширхэг баганыг Өлгий хүртэл тээвэрлэж дууссан байна. Иймд дээрх хоёр гэрээ нь цаг хугацааны хувьд ямар ч уялдаагүй, тээвэр хийсэн иргэний дансанд мөнгө шилжүүлсэн талаар нотлох баримт байхгүй байна.

Аудитын явцад төслийн инженер Х.Жардемээс Алтай таван богд, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын чиглэлд 2022 онд 12 метрийн 204 ширхэг, 2023-2024 онд 1567 ширхэг, нийт 1771 ширхэг баганыг суурилуулсан гэсэн тайлбар ирүүлсэн.

Аудиторуудын хийсэн тооцоогоор гаалиар Хятад улсаас 1663 ширхэг багана орж ирсэн, “Проект Ватт” ХХК-наас 100 ширхэг багана худалдаж авсан ба нийт 1763 ширхэг багана гарч байна. Төслийн талбар руу тээвэрлэгдсэн багана, нийт худалдаж авсан баганы хооронд 8 баганын зөрүүтэй байна. Иймд төслийн талбар дээр тавьсан баганын тооцоог төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс гаргаж, тооцоо нийлэх нь зүйтэй байна.

Хятад улс руу 2022, 2023, 2024 онуудад баганы үнэ гэж нийтдээ 1,050.7 сая төгрөг шилжүүлсэн. Үүнээс гаалийн мэдүүлгээр баталгаажиж импортоор орж ирсэн баганы тоо ширхгээр 1663, гаалийн мэдүүлэг дэх барааны мөнгөн дүн 868,079 юань бөгөөд нийт 34 удаагийн гаалийн мэдүүлгийн дунджаар тооцож үзэхэд нэг ширхэг баганы дундаж үнэ 524.16 юань гарч байна.

Тус газраас ГЕГ-т албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийн дагуу ГЕГ-аас 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн гаалийн мэдүүлэг, холбогдох баримт бичигт ЦШСГ-ын 2023 оны 3 дугаар сарын хоёр төрлийн гэрээ ирүүлсэн болно. Нэг гэрээ нь монгол хэлээр, нөгөөх нь хятад хэлээр бичигдсэн байна. Монгол хэлээр бичигдсэн гэрээнд Цахилгаан шугам сүлжээний газарт нийлүүлэх 1 ширхэг баганын үнийг 500 юаньаар тооцож, Тайкешкен боомт хүртэлх тээвэрлэлтийг үйлдвэрлэгч тал хариуцахаар тусгасан байна.

Хятад хэлээр бичигдсэн гэрээндээ нэг баганыг 670 юанаар нийлүүлнэ, тээвэрлэлтийг худалдан авагч тал хариуцна гэж тусгажээ.

Иймд Хятад улсад баганы үнэд 1,050.7 сая төгрөгийг шилжүүлсэн боловч хэдэн ширхэг багана орж ирэх ёстой байсныг аудит хийх явцад тогтоох боломжгүй байгаа тул энэхүү асуудлыг хуулийн байгууллагаар шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

2. Хятад улсын Эрээн хотод бусад дагалдах сэлбэг хэрэгсэл худалдан авахаар 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр Yongxing Electric power material ХХК-аас 60 тн АС-50/8 кабел утас 1 тн утасны үнэ 16,800 юань нийт 1,008,000 юань, 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Yongxing Electric power material ХХК-аас нийт 595,675 юаны дагалдах сэлбэг хэрэгсэл, 2 компанитай гэрээ байгуулж бусад сэлбэг хэрэгсэл татахаар 2023, 2024 онд нийтдээ 1,603,675 юань шилжүүлсэн байна.

ГЕГ-аас ирүүлсэн Замын үүд боомтоор орж ирсэн барааны гаалийн мэдүүлэг болон худалдан авах гэрээнд ЦШСГ нь Yongxing Electric power material ХХК-аас 60 тн АС-50/8 кабел утас 1 тн утасны үнэ 13,000 юань нийт 780,000 юаньаар, Yongxing Electric power material ХХК-аас нийт 417,329 юаны дагалдах сэлбэг хэрэгсэл худалдан авахаар тусгасан байна.

Үүнээс үзэхэд байгууллагын санхүү болон гаалийн байгууллагад хоёр өөр дүнтэй гэрээ байгаа бөгөөд хоёр гэрээний үнийн дүнгийн зөрүү 406,346 юань байгааг аудитын явцад тогтоох боломжгүй байгаа тул хуулийн байгууллагаар шалгуулах нь зүйтэй байна.

3. Иргэн Алтанцэцэгийн дансанд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 58.7 сая төгрөг, 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 30.1 сая төгрөгийг ямар нэгэн гэрээ хийхгүйгээр шилжүүлсэн ба гаалийн татварт 8.4 сая төгрөг төлөгдсөн байна. Энэхүү бараа нь Ховд аймгийн Булган сумын Ярант боомтоор 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 698 уут цемент, 2 дамар кабель утас, 80 хайрцаг щитний хайрцаг, 10 хайрцаг тусгаарлагч шаазан орж ирсэн гэх боловч гаалийн мэдүүлгээр 88.8 сая төгрөгийн бараа орж ирснийг батлах боломжгүй байна. Гэтэл санхүүгийн баримтад 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн бэлтгэн нийлүүлэгч талын зарлагын падааныг үндэслэж, барааг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр орлого авснаар санхүүгийн бүртгэл, тайланд тусгасан байна.

2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Ховд аймгийн Булган сумын Ярант боомтоор 698 уут цемент орсноор гаалийн мэдүүлэгт тусгагдсан боловч 25 тн буюу 500 уут цемент орж ирснийг хүлээн авсан гэж дарга, нягтлан бодогчид тайлбарласан бөгөөд 198 уут цемент орж ирсэн эсэхийг тогтоох боломжгүй байна.

- Ачаа тээврийн зардал болон түрээсээр авч ажиллуулсан техникийн ажлын хөлсөнд нийтдээ 578.2 сая төгрөгийг олгосон бөгөөд хилийн боомтоос ачаа тээвэрлэсэн тээврийн гэрээг жолооч бүртэй хийгээгүй, мөнгө олгохдоо цахим е-баримтыг бүрдүүлж аваагүй, холбогдох хуулийн дагуу татвар суутгаагүй олгосон байна.

Аудитын дүнгээр илэрсэн дараах зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

- ЦШСГ нь хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж, Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамж төслийн арга хэмжээнд 2022-2024 онд нийтдээ 4314.9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан боловч санхүүгийн тайланд орлогоор бүртгэж тайлагнаагүй, зардлыг бүртгээгүй, дуусаагүй барилга байгууламжид бүртгэж тайлагнаагүй."Проект ватт" ХХК-аас худалдан авсан 100 ширхэг, Хятад улсаас худалдан авсан 1663 ширхэг, нийт 1763 ширхэг цахилгааны шугамын баганыг орлого аваагүй,

- Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамжийн ажилд 2023 онд 314.5 сая төгрөгийн, 2024 онд 746.3 сая төгрөгийн, ХЦ-ийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамжийн ажилд 2023 онд 414.7 сая төгрөгийн, 2024 онд 541.2 сая төгрөгийн буюу 2024 оны жилийн эцэст нийтдээ 1,287.5 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан. Санхүүгийн программаас өглөг үүсэн байдлыг шалгаж үзэхэд энэ нь нийт хүлээж авсан санхүүжилт, төслийн зардал хоёрын зөрүүгээр өглөг тайлагнасан нь бодитой биш бөгөөд, бичилтийн алдаанаас үүдэлтэй өглөгийг бүртгэж тайлагнасан.

- Төслийн ажилд 2023 онд Голомт банкнаас 295.0 сая төгрөгийн, аж ахуйн нэгж, иргэдээс 618.9 сая төгрөгийн, 2024 онд 608.0 сая төгрөгийн, нийтдээ 1,521.9 сая төгрөгийн зээл авч, 82.2 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал гаргасан. Энэхүү зээлийг авахдаа ЦШСГ-ын Удирдах зөвлөлд танилцуулж, зохих зөвшөөрөл аваагүй.

- Иргэн Алтанцэцэгийн дансанд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 58.7 сая төгрөгийг, 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 30.1 сая төгрөгийг ямар нэгэн гэрээ хийхгүйгээр сэлбэг худалдан авахаар шилжүүлсэн, "Өлгий бид" ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр 9.0 сая төгрөг шилжүүлсэн бөгөөд гүйлгээ хийсэн төлбөрийн даалгавар, санхүүгийн анхан шатны баримт байхгүй, ямар нэг бараа материал орлого аваагүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгэж харуулаагүй.

- Алтай таван богдын байгалийн цогцолборт газар, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамжаар хангах төслийн санхүүжилтийн гүйцэтгэлийг шалгаж үзэхэд гаалийн мэдүүлэг болон барааны гэрээ, тээврийн гэрээ зэрэг анхан шатны баримтыг бүрэн гүйцэт бариментад хавсаргаагүй, Хятад улсад баганын үнийг иргэн Алтанцэцэгт шилжүүлэхдээ хэдэн баганын үнэ шилжүүлж байгаа нь тодорхой бус, шилжүүлсэн мөнгөн дүнд тохирсон багана гаалиар хэзээ орж ирснийг тэмдэглээгүй, мөн баганын тээврийг тооцоог гаргаж хавсаргаагүй, тээвэр хийсэн иргэдээс цахим е-баримтыг авч санхүүгийн баримт материалд хавсаргаагүй, бүртгэл, тооцоо, тайлагналыг зохих журмаар хийгээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хангалтгүй зохион байгуулсан.

Мөн гаалиар орж ирсэн цементийг данс бүртгэлд тусгаагүй, ажилчдад тараасан боловч үнийг нь дансанд оруулаагүй, авлагаар бүртгэж харуулаагүй 498 уут цементийн үнэ нэг бүрийн 13,500 төгрөгөөр тооцож 6.7 сая төгрөгийг нэр бүхий ажилчдаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

"Суат" ХХК-ны орлого бүрдүүлэлт, тайлагналын талаар: "Суат" ХХК-ний 2023-2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор нь ангилж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №12 "Суат" ХХК-ний 2023-2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа / сая төгрөгөөр/

Үйл ажиллагааны төрөл	Цех, тасаг	2023 он		2024 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Үндсэн үйл ажиллагаа	Цэвэр ус	670,8	722,1	1,033,7	1,190,1
	Бохир ус	574,8	636,5	921,6	768,6
	Халуун ус	201,7	230,2	226,3	296,1
	Техникийн нөхцөл	35,0	51,4	35,0	61,9
	Дүн	***1,482,5***	***1,640,2***	***2,216,5***	***2,316,7***
Туслах үйл ажиллагаа	Барилга угсралт	20,0	13,3	20,0	5,0
	Түрээс	15,5	15,3	15,5	18,0
	Дүн	***35,5***	***28,6***	***35,5***	***23,0***
Бүгд дүн		**1,517,9**	**1,668,8**	**2,252,1**	**2,339,8**

Эх сурвалж: Аудитын судалгаа

Гүйцэтгэлээр нийт орлого 2023 онд 9 хувиар буюу 150.8 сая төгрөгөөр, 2024 онд 3.7 хувиар буюу 87.7 сая төгрөгөөр өссөн байна.

2023 онд нийт орлогын 43.3 хувийг цэвэр усны, 38.1 хувийг бохир усны, 13.8 хувийг халуун усны, 3.1 хувийг техникийн нөхцөлийн орлого буюу үндсэн үйл ажиллагаанаас 98.3 хувийг, туслах үйл ажиллагаанаас 1.7 хувийг бүрдүүлсэн.

2024 онд нийт орлогын 50.8 хувийг цэвэр усны, 32.8 хувийг бохир усны, 12.6 хувийг халуун усны орлого, 2.1 хувийг техникийн нөхцөлийн орлого буюу үндсэн үйл ажиллагаанаас 98.3 хувийг, туслах үйл ажиллагаанаас 1.7 хувийг бүрдүүлжээ.

Бохир усны орлого нь 2024 онд 16.6 хувиар буюу 152.9 сая төгрөгөөр тасарсан нь ноос угааж боловсруулах үйл ажиллагаа явуулдаг “Файнос” ХХК-ны үйл ажиллагаа зогссон, барилга угсралтын орлого 2023 онд 33.5 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр, 2024 онд 75 хувиар буюу 15.0 сая төгрөгөөр тасарсан нь төлбөртэй үйлчилгээний орлого дутуу орсонтой холбоотой байна.

Орлогын гүйцэтгэлийг салбараар нь авч үзвэл 2023 онд орон сууц, гэр хорооллын айл, өрхийн орлого 63.4 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын орлого 49.1 сая төгрөгөөр, халуун усны түрээсний орлого 39.2 сая төгрөгөөр, аж ахуйн нэгжийн орлого 0.3 сая төгрөгөөр нийтдээ 152.1 сая төгрөгөөр давж, бусад орлого 1.3 сая төгрөгөөр тасарсан.

2024 онд халуун усны түрээсний орлого 69.8 сая төгрөгөөр, орон сууц, гэр хорооллын айл, өрхийн орлого 55.4 сая төгрөгөөр, бусад орлого 14.4 сая төгрөгөөр нийтдээ 139.6 сая төгрөгөөр давж, төсөвт байгууллагын орлого 43.8 сая төгрөгөөр, аж ахуйн нэгжийн орлого 8.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №13 Борлуулалтын орлогыг хэрэглэгчээр ангилсан судалгаа / сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2023	2024
Худалдаа үйлчилгээний байгууллага /ААНэгж/	329,0	465,6
Төсөвт байгууллага	552,3	836,9
Орон сууц, гэр хороолол /Айл өрх/	477,2	656,2
Халуун ус /Түрээс/	230,2	296,1
Бусад борлуулалтын орлого/	80,0	84,9
Орлогын дүн	**1,668,8**	**2,339,8**

Эх сурвалж: Суат ХХК-ний санхүүгийн тайлан

Борлуулалтын орлогын бүтцийг авч үзвэл 2023 онд 33 хувийг төсвийн байгууллагуудаас, 28.6 хувийг айл өрхүүдээс, 19.7 хувийг аж ахуйн нэгжүүдээс, 13.8 хувийг халууны усны, 4.8 хувийг бусад үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна.

2024 онд 35.8 хувийг төсвийн байгууллагуудаас, 28 хувийг айл өрхүүдээс, 19.9 хувийг аж ахуйн нэгжүүдээс, 12.7 хувийг халууны усны, 6.6 хувийн бусад үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна.

Хүснэгт №14 Цэвэр усны шугамд холбогдсон хэрэглэгчийн судалгаа

	Нийт хэрэглэгч	Шинэ хэрэглэгч

Айл өрх, ААНБ	2022	2023	2024	2023	2024
Орон сууц	1437	1530	1717	93	187
Гэр хороолол / айл өрх/	760	848	903	88	55
Төсөвт байгууллага	60	78	78	18	0
ААНБ	235	266	280	31	14
Дүн	**2492**	**2722**	**2978**	**230**	**256**

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дээрх хүснэгтээр харахад 2023 онд 230 хэрэглэгч, 2024 онд 256 хэрэглэгч шинээр нэмэгдсэн байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зохицуулах хорооны 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 87 дугаар тогтоолоор төсөвт байгууллагын цэвэр бохир усны үнэ тарифыг нэмж, бусад байгууллага, айл өрхийн үнэ тарифыг дараа сарын 01-ний өдрөөс нэмэгдэж, төсөв байгууллагын нэмэгдсэн үнэ тарифыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахаар тогтоосон байна.

Үүнд цэвэр усны үнэ тариф 54.2-62.5 хувиар, бохир усны үнэ тариф 54.2-62.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт №15 Авлагын харьцуулсан судалгаа */сая төгрөгөөр/*

Авлага	2022	2023	2024
Төсөвт байгууллага	11,4	51,4	93,7
Аж ахуйн нэгж	72,8	73,0	96,6
Айл өрх	57,9	84,3	103,7
Бусад	19,0	23,4	31,0
Дүн	**161,2**	**232,1**	**325,2**

Эх сурвалж: “Суат” ХХК-ны санхүүгийн тайлан

“Суат” ХХК-ны авлага 2023 оны эцэст 232.1 сая төгрөг, 2024 оны эцэст 325.2 сая төгрөг болж тус тус нэмэгдсэн байна. 2024 оны эцсийн байдлаар нийт авлагын 28.8 хувийг төсөвт байгууллагын, 29.7 хувийг аж ахуйн нэгжийн, 31.8 хувийг айл өрхийн, 9.6 хувийг бусад авлага эзэлж байна.

Авлага нэмэгдсэн шалтгааныг судалж үзэхэд цэвэр, бохир усны үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой төсөвт байгууллагууд цэвэр, бохир усны төсвийг нэмэгдсэн үнэ тарифт уялдуулан төлөвлөж батлуулаагүй, үүнээс гадна айл өрх, бусад байгууллагууд цэвэр, бохир усны заалтыг 20-ны дотор авч авлага үүсгэх бичилт хийдэг ба хэрэглэгч тухайн сарын төлбөрийг 20-30 хонгийн дотор төлөх үүрэгтэй холбоотой байна.

1.2.3 Удирдлагын зардлын төлөвлөлт, хяналт хангалтгүй байна

ЦШСГ нь 2023-2024 онд удирдлагын зардлыг тусдаа төлөвлөж, тайлагнаагүй, үйл ажиллагааны зардалтай хамт төлөвлөж, тайлагнаж байгаа нь удирдлагын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд үнэн зөв дүгнэлт өгөх боломжгүй байна.

Илрүүлэлт:

- Тээвэр шатахууны зардлаас 2024 онд зарцуулсан 18.8 сая төгрөгийн шатахууны талон байхгүй, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, тооцооны хуудаст гүйлтийн спидометрийн заалт бичээгүй, зарим тооцооны хуудаст хяналт хийсэн албан тушаалтан гарын үсэг зураагүй, дуудлага, гэмтэлд явсан эсэх нь тодорхойгүй, ажлын тайлан илтгэх хуудасгүй, дуудлагын бүртгэлийн дэвтрээс тулгалт хийх боломжгүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй.

Удирдлагын зардлыг үйл ажиллагааны зардлаас салгаж тусад нь төлөвлөж ажиллахыг зөвлөмж болгов.

"Суат" ХХК-ний удирдлагын зардлыг зардлын нэр төрлөөр дэлгэрэнгүй төлөвлөж, гүйцэтгэлээр 2023 онд 271.8 сая төгрөг, 2024 онд 359.1 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт №16 Удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа / төгрөгөөр/ (дэлгэрэнгүй судалгааг хавсралт №03-аас харна уу)

Үзүүлэлт	Төлөвлөгөөний харьцуулалт		Зөрүү	2024 он		2024 оны хэтрэлт, хэмнэлт
	2023 он	2024 он	2024-2023	төлөвлөгөө	гүйцэтгэл	
Нийт дүн	**271,544,568.6**	**404,274,816.0**	**132,730,247.4**	**404,274,816.0**	**359,091,798.8**	**(45,183,017.2)**

Эх сурвалж: Суат ХХК-ны удирдлагын зардлын судалгаа

Удирдлагын зардлыг 2023 онд өмнөх оноос 37.7 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар, 2024 онд өмнөх оноос 132.7 сая төгрөгөөр буюу 48.8 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Энэ нь захиргааны зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүй байгааг харуулж байна.

Илрүүлэлт:

"Суат" ХХК-ны гүйцэтгэх захирал байгууллагын 7799БӨА дугаартай Lexsus 470 суудлын авто машинаар 2023 онд 1632 литр буюу 4.5 сая төгрөгийн, 2024 онд 1060 литр буюу 2.9 сая төгрөгийн шатахууныг нэг сард 5-9 удаагийн давтамжтайгаар 100-175 литр шатахуунаар хот дотор ямар ажлаар явсан нь тодорхойгүй, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалтгүй, анхан шатны бүрдэл дутуу бариматаар, үр ашиггүй, хяналтгүй зарцуулсан.

Албан томилолтод 2024 онд зарцуулсан 34.9 сая төгрөгийн томилолтыг бүрэн гүйцэт таглаагүй, томилолтоор ажилласан тухайн албан хаагчийн илтгэх хуудасгүй, томилолтоор ажиллах болсон шалтгаан, үр дүн тодорхойгүй, анхан шатны бариматын бүрдлийг хангаагүй байна.

ТУЗ-ийн 2023.01.16-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор компани захиралд 25 хувиар ур чадварын нэмэгдэл тогтоож олгосон боловч ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлаагүй, 2024 онд 25 хувиар 7.0 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг холбогдох шийдвэргүйгээр олгосон.

Гүйцэтгэх захиралд ТУЗ-ийн шийдвэргүйгээр 2023 онд 0.3 сая төгрөгийн, 2024 онд 0.4 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.

Захирлын 2023.12.25-ны өдрийн "Шагнах тухай" А/28 дугаар тушаалаар ХАС банкин дахь харилцах данснаас 2023.12.26-ны өдөр 1052.0 мянган төгрөгийг, 2024.02.21-ний өдөр 292.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч кассаас анхан шатны баримтыг давхар бүрдүүлж 1344.0 мянган төгрөгийг илүү зарлага гаргасан.

Гүйцэтгэх захирлын 2022 оны А/17 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2.2-т мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдлийг 15 хувиар олгохоор заасан боловч эдийн засагч бөгөөд дотоод аудиторт 2019 оноос нэмэгдлийг 20 хувиар буюу 5 хувиар илүү олгосон

Нярав нь аж ахуй, бараа материалын тайланг зохих журмын дагуу гаргаагүй, жолоочийн шатахууны тооцоог журмын дагуу хийгээгүй, кассын анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн.

Удирдлагын зардлыг ямар тооцоо, судалгаанд үндэслэж хийснийг нотлох баримт байхгүй байна.

Аудитын дүнгээр Төлөөлөн удирдах зөвлөлд үр чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлах, ажлын үр дүнгээр олгох, Компанийн удирдлагад үр ашиггүй зардлыг бууруулахыг зөвлөмж болгов.

1.2.4 Үр ашиггүй зардлыг бууруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар хангалтгүй ажилласан байна

ЦШСГ-ын үйл ажиллагааны зардал (тарифт зардал)-ыг 2023 онд төлөвлөснөөс 161.4 сая төгрөгөөр, 2024 онд 22.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Хүснэгт №17 ЦШСГ-ын 2023-2024 оны зардлын судалгаа *сая.төгрөг*

Зардлын төрлүүд	2023 он		өөрчлөлт		2024 он		өөрчлөлт	
	Төл	Гүй	биет	Хувь	Төл	Гүй	биет	Хувь
Үндсэн, нэмэгдэл цалин	1,943.0	1,957.8	14.8	100.8	2,415.3	2,413.8	(1.5)	99.9
ЭМ, НДШ	281.7	283.9	2.2	100.8	350.2	350.0	(0.2)	99.9
Шатахуун	114.3	94.2	(20.1)	82.4	124.2	102.0	(22.2)	82.1
Урсгал засвар	12.0	42.6	30.6	355.0	13.0	26.7	13.7	205.4
Тээвэр	13.5	13.4	(0.1)	99.3	14.7	11.4	(3.3)	77.6
Ашиглалтын зардал	39.6	38.6	(1.0)	295.6	43.0	36.4	(6.6)	268.9
Албан томилолт	22.0	21.8	(0.2)	99.1	24.0	28.7	4.7	119.6
Сэлбэг хэрэгсэл	328.8	311.4	(17.4)	94.7	357.4	336.8	(20.6)	94.2
Гадны үйлчил хөлс	72.0	83.7	11.7	116.3	78.3	89.3	11.0	114.0
Сургалт	2.3	2.3	-	100.0	2.5	3.6	1.1	144.0
Бусад зардал	122.9	130.7	7.8	1,152.8	138.2	100.2	(38.0)	913.6
ҮА-ны бусад зардал	-	21.0	21.0		-	-	-	
ҮА-ны зардал	**2,952.1**	**3,001.4**	**49.3**	**2,596.7**	**3,560.8**	**3,498.9**	**(61.9)**	**2,219.2**
Элэгдэл	876.0	1,025.1	149.1	117.0	889.3	1,092.2	202.9	122.8

ОАТ-аас бусад татвар	**8.7**	**5.6**	(3.1)	64.4	**8.8**	**5.5**	(3.3)	62.5
Бүрэн өөрийн өртөг	**3,836.8**	**4,032.1**	**195.3**	**2,778.1**	**4,458.9**	**4,596.6**	**137.7**	**2,404.5**
Нийгмийн зардал	287.1	253.4	(33.7)	88.3	667.7	552.2	(115.5)	82.7
Тарифт зардал-БОХШ	**4,123.9**	**4,285.5**	**161.6**	**2,866.4**	**5,126.6**	**5,148.8**	**22.2**	**2,487.2**

Эх сурвалж: ЦШСГ-ын үйл ажиллагааны тайлан

Цалингийн зардлыг 2023 онд 14.8 сая төгрөгөөр хэтрүүлж, 2024 онд 1.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2023 онд урсгал засварыг 55%-иар буюу 30.6 сая төгрөгөөр, гадны үйлчилгээний хөлс 16.3%-иар буюу 11.7 сая төгрөгөөр, элэгдлийн зардлыг 17.0%-иар буюу 149.1 сая төгрөгөөр хэтрүүлж, төлөвлөгдөөгүй үйл ажиллагааны бус 21.2 сая төгрөгийн зардал гаргасан байна.

2024 онд урсгал засвар 13.7 сая төгрөгөөр, албан томилолт 4.7 сая төгрөгөөр, гадны үйлчилгээний хөлс 11.0 сая төгрөгөөр, сургалтын зардал 1.1 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 202.9 сая төгрөгөөр хэтэрч, бусад зардлыг төлөвлөсөн хэмжээнд зарцуулсан байна.

Урсгал засварын зардал зайлшгүй хийх төлөвлөгдөөгүй засвар гарсантай холбоотой байна. Нийгмийн зардал хэмнэлттэй гарсан нь зарим ажилчид тухайн онд тэтгэвэрт гараагүйтэй, гадны үйлчилгээний хөлс нэмэгдсэн нь цахилгааны төлбөрийг бэлэн бусаар карт болон киоск машинаар төлсөнтэй холбоотой байна.

ТУЗ-өөс 2023 оны бизнес төлөвлөгөөг үндэслэн газрын бүтэц, орон тоо, цалин, үр дүнгийн урамшууллыг баталсан боловч 2024 онд батлаагүй байна.

ЦШСГ-ын даргын 2023 оны 01 дүгээр тушаалаар 2023 оны бүтэц, орон тоог 92, 2024 оны А/01 дүгээр тушаалаар 94 хүнээр баталсан байна.

Хүснэгт № 18 Цалин, урамшууллын зардал, орон тооны судалгаа (сая төгрөг)

Үзүүлэлт	**2023**			**2024**		
	Батлагдсан	*Гүйцэтгэл*	*Зөрүү*	*Батлагдсан*	*Гүйцэтгэл*	*Зөрүү*
Цалин, урамшуулал	1,943.0	1,957.8	14.8	2,415.3	2,413.8	(1.5)
Орон тоо	92	89	-3	94	89	-5

Эх сурвалж: ЦШСГ-ын санхүүгийн тайлангаас

Гүйцэтгэлээр 3-5 орон тоогоор хэмнэлттэй ажилласан нь 2023 онд 5, 2024 онд 4 ажилтан тэтгэвэрт гарсан, нэг ажилтан өөрийн хүсэлтээр чөлөө авсан, шинээр бий болсон 2 орон тоонд ажилтан аваагүйтэй холбоотой байна.

Удирдах зөвлөлийн тогтоолоор 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс ажиллагсдын үндсэн цалинг 216.0 мянган төгрөгөөр, 2024 01 дүгээр сарын 01-нээс 290.0 мянган төгрөгөөр, 2024 оны 05 дугаар сараас 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхээр шийдвэрлэжээ. Газрын даргын 2023 оны 15, 2024 оны Б/05 дугаар тушаалаар албан хаагчдын цалингийн жишгийг шинэчлэн баталсан байна.

Эрчим хүчний салбарын Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.6 дахин нэмэгдүүлж тогтоосныг ажиллагсдад өндөр насны тэтгэвэрт гарах, нэг удаагийн буцалтгүй тусламж, мөнгөн шагнал олгохдоо энэхүү доод хэмжээг баримталсан байна.

"Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээр"-ийг үндэслэн ЦШСГ-ын захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороо нь 2022, 2024 онд хамтын гэрээ байгуулж, эрх бүхий захиргааны байгууллагад бүртгүүлсэн байна.

Хамтын гэрээний 3.11 дэх заалтад "Ажиллагсдад сарын ажлын үр дүнгийн шагналыг албан тушаалын үндсэн /тарифт/ цалингийн 50 хүртэл хувиар олгоно" гэж заасны дагуу ажилчдад сар бүр үндсэн цалингийн 50 хүртэлх хувиар үр дүнгийн шагнал олгосон байна.

Удирдах зөвлөлийн 2023 оны 03, 2024 оны 02 дугаар тогтоолоор жилийн үр дүнгийн урамшууллын цалинг үндсэн цалингийн 2.5 сараар тооцож олгосон байна.

Хамтын гэрээний дагуу сарын ажлын үр дүнгийн урамшуулалд 2023 онд 278.4 сая төгрөг, 2024 онд 390.9 сая төгрөг, жилийн үр дүнгийн урамшуулалд 2023 онд 155.7 сая төгрөг, 2024 онд 170.6 сая төгрөг олгосон байна.

Илрүүлэлт:

- *Кассаас цохолт хийсэн 1, 2 дугаар гарын үсгийн аль нэг нь дутуу, бэлэн мөнгө, шагнал, тусламж олгохдоо хүлээн авсан хүний гарын үсэг дутуу, анхан шатны бүрдэл дутуу бариманаар 61.6 сая төгрөгийг бэлэн олгосон,*
- *Ажилчдын цалингаас 2023 онд ҮЭ-ийн татварт 14.1 сая төгрөгийн суутгал хийж, 19.9 сая төгрөг зарцуулж, суутгасан дүнгээс 5.0 сая төгрөгийг илүү зарцуулсныг авлагаар тусгаагүй байгууллагын зардлаас гаргасан, 2024 онд 18.9 сая төгрөгийн ҮЭ-ийн татвар суутгасан боловч орлого, зарлагын тооцоог хийгээгүй байна.*
- *Хамтын гэрээнд заасны дагуу ажиллагсдад үр дүнгийн урамшуулал олгож байгаа боловч сарын ажлын үр дүнг үнэлж дүгнэх журам батлаагүй, ажлыг бодитой үнэлж дүгнээгүй байна.*
- *Аудитаар сахилгын шийтгэлтэй хугацаанд олгосон 4.8 сая төгрөгийн урамшуулал, байгууллагаас төлсөн 5.8 сая төгрөгийн актын төлбөр, суутгаагүй цалингийн урьдчилгаа 24.8 сая төгрөг, суутгаагүй 1.0 сая төгрөгийн ХХОАТ, дутуу төвлөрүүлсэн 20.7 сая төгрөгийн техникийн нөхцөлийн суурь хураамж, гэрээний дүнгээс илүү шилжүүлсэн 5.0 сая төгрөг, ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгт нотлох баримтгүй "Өлгий таван гал" ХХК-д шилжүүлсэн 4.8 сая төгрөгийн зөрчилд акт тогтоов.*
- *Анхан шатны бүрдэл дутуу бариманаар зарцуулсан 80.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.*
- *Ажиллагсдын ажлын үр дүнг үнэлэх журам баталж, үр дүнгийн урамшуулал олгохдоо ажлын үр дүнг бодитой үнэлж дүгнэх, цалингаас суутгасан Үйлдвэрчний эвлэлийн татварын тооцоог тухай бүр хийхийг зөвлөмж болгов*

“Суат” ХХК-ний үйл ажиллагааны зардалд 2023 онд 1,383.6 сая төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 1,488.8 сая төгрөг зарцуулан 105.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн, 2024 онд 1,781.1 сая төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 1,770.0 сая төгрөг зарцуулан 11.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт №19 Үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа *сая төгрөг*

д/д	Зардлын төрөл	2023 он		Хэтрэлт, хэмнэлт	2024 он		Хэтрэлт, хэмнэлт
		Төлөвлөгөө	**Гүйцэтгэл**		**Төлөвлөгөө**	**Гүйцэтгэл**	
1	Ажиллагчдын цалингийн зардал	641,3	678,4	(37,)	856,2	903,3	47,1
2	НДШ-ийн зардал	86,6	93,6	(6,9	115,6	127,1	11,5
3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	8,3	11,2	(2,9)	11,4	10,5	(0,8)
4	Томилолтын зардал	4,0	4,5	(0,5)	10,	18,8	8,7
5	Бичиг хэргийн зардал	2,7	1,9	0,8	2,8	7,5	4,6
6	Шуудан холбооны зардал	3,4	6,6	(3,2)	7,8	7,9	0,1
7	Сэлбэг хэрэгсэл	8,9	20,4	(11,5)	12,5	23,3	10,7
8	Сургалтын зардал	3,0	0,9	2,1	6,3	5,0	(1,3)
9	Тоног төхөөрөмж	-	30,7	(30,7	6,5	-	(6,5)
10	Даатгалын зардал	4,3	2,9	1,4	3,0	4,3	1,3)
11	Ашиглалтын зардал	251,3	278,9	(27,6)	313,1	298,1	(14,9)
12	Засварын зардал	30,4	41,7	(11,2)	83,2	26,8	(56,4)
13	Элэгдэл, хорогдлын зардал	192,5	196,4	(3,8)	196,9	205,2	8,2
14	Ажиллагсдын нийгмийн зардал	51,4	33,5	17,8	45,8	17,6	(28,1)
15	Үйлчилгээний зардал	-	-	-	13,0	13,0	0
16	Гаднын үйлчилгээний хөлс	-	-	-	12,0	30,2	18,2
17	Тээврийн зардал	1,2	1,3	(0,1)	2,5	1,3	(1,2)
18	Шатахууны зардал	22,9	25,	(2,7)	29,1	36,0	6,9
19	Зар сурталчилгааны зардал	0,9	0,2	0,7	0,3	0,	(0,3)
20	Хангамжийн материал	10,8	10,6	0,2	17,1	17,4	0,3
21	Хөдөлмөр хамгааллын зардал	19,5	10,7	8,7	35,7	14,0	(21,7)
22	Бусад	40,0	38,3	1,7	-	2,3	2,3
	Нийт	**1,383,6**	**1,488,8**	**(105,2)**	**1,781,1**	**1,770,0**	**(11,1)**

Эх сурвалж: Аудитын судалгаа

<u>Зардал хэтрэхэд дараах зүйл нөлөөлжээ</u>. Үүнд:

- Цахилгааны зардлын тариф нэмэгдсэнтэй холбоотой 27.7 сая төгрөгийн нэмэлт зардал гарсан,
- Төлөвлөгөөндөө тусгаагүй айл өрх, албан байгууллагуудад 30.8 сая төгрөгийн тоолуур тавьсан,
- CAT-416 экскаваторт 11.5 сая төгрөгийн, 45 квт болон 65 квт 2 ширхэг насосын 11.2 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй засвар хийгдсэн,

- Ажилчдад 14.0 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт, барилгын угсралтын ажлын хөлс, шөнийн нэмэгдэлд 15.0 сая төгрөг олгосон байна.

Тус компанийн үйл ажиллагааны зардлыг тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөөгүй байна. Тухайлбал:

2024 онд цалин хөлсний зардлыг 58.6 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 8.7 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 4.7 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгслийн зардал 10.8 сая төгрөгөөр, гаднын үйлчилгээний хөлс 18.2 сая төгрөгөөр, шатахууны зардлыг 6.9 сая төгрөгөөр, элэгдэл, хорогдлын зардлыг 8.2 сая төгрөгөөр хэтрүүлж, засварын зардлыг 56.4 сая төгрөгөөр, ашиглалтын зардлыг 15.0 сая төгрөгөөр, ажиллагсдын нийгмийн зардлыг 28.1 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардлыг 21.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 1998-2001 онд хэрэгжсэн “Орон нутгийн хотуудын НАА-г сайжруулах” төсөлд хамрагдаж 1.0 сая долларын хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн бөгөөд 2021.12.31-ний өдрийн байдлаар санхүүгийн тайлан дахь урт хугацаат зээлийн үлдэгдэл 991.0 сая төгрөг ба урт хугацаат зээлийг 2004.06.01-ний өдрөөс эхлэн 2018.12.01-нийг хүртэл хагас жил тутамд сар бүр 53625-аас 40900 доллар төлөх хуваарьтай байна.

Сангийн яам 2022 оноос аймгийн орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс тус компанийн хугацаа хэтэрсэн урт хугацаат зээлийн төлбөрт 2022 онд 331.0 сая төгрөгийг, 2023 онд 65.5 сая төгрөгийг, 2024 онд 172.2 сая төгрөгийг нийтдээ 568.8 сая төгрөгийг суутган төлүүлсэн байна.

Урт хугацаат зээлийн төлөгдсөн хэмжээгээр богино хугацаат өр төлбөрт шилжүүлэн бүртгэсэн боловч төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээг төлөвлөж ажиллаагүй байна.

Компани удирдлагын болон үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг эдийн засагч нь боловсруулж гүйцэтгэх захирлаар батлуулсан боловч удирдлагын зардлыг ямар тооцоо, судалгаанд үндэслэж хийснийг нотлох баримт байхгүй байна.

Илрүүлэлт:

- ✓ Бэлэг дурсгал, шагнал, урамшуулал, хүлээн авалтад 2023 онд 5.6 сая төгрөгийн, 2024 онд 6.5 сая төгрөгийн, баруун бүсийн сургалт, зөвлөгөөнд оролцсон 31 албан хаагчид 2024 онд 4.3 сая төгрөгийн биеийн тамирын хувцас худалдаж авч үргүй зардал гаргасан.
- ✓ Тус аймагт 2023 онд зохион байгуулагдсан баруун бүсийн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын уулзалт зөвлөгөөн, спортын арга хэмжээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар тогтоолоор 20.0 сая төгрөг зарцуулах шийдвэр гаргуулж, гүйцэтгэлээр бэлэг дурсгал, шагнал, хүлээн авалтад 22.2 сая зарцуулсан.
- ✓ Нэг алба хаагчид 2023 онд олгосон 0.4 сая төгрөгийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж тайлагнаагүй орхигдуулсан.

“Суат” ХХК-ны ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор компанийн бүтэц орон тоог 75, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор 76 орон тоогоор буюу тоолуурын техникч, засварчны орон тоог нэмж баталсан байна.

Хүснэгт №20 Бүтэц орон тооны судалгаа

№	Алба, хэсгийн нэр	Орон тоо	
		2023 он	2024 он
1	Удирдлагын алба	6	6
2	Захиргаа, аж ахуйн алба	6	6
4	Санхүү, борлуулалтын алба	13	13
5	Ус хангамж, ариутгах татуургын хэсэг	34	35
6	Лабораторийн хэсэг	3	3
7	Халуун усны хэсэг	13	13
	Бүгд	**75**	**76**

Эх сурвалж: ТУЗ-ын 2023 оны 03, 09 дүгээр тогтоолын хавсралт

Компанийн бүтцэд менежер, хүний нөөцийн менежер бөгөөд захиргаа удирдлагын хэлтсийн дарга, тоолуурын техникч, засварчин, борлуулалтын ажилтан зэрэг орон тооны чиг үүргийн давхардал байгаа нь ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд нөлөөлсөн байна.

Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны ажлын хэсгийн шалгалтаар тус компанийн бүтэц орон тоо болон ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу нийт 10 байцаагч, борлуулалтын нягтлан, усны инженер нь 2690 айл өрх, 368 аж ахуй нэгж байгууллага буюу нийт 3058 хэрэглэгчийн цэвэр, бохир усны төлбөр тооцоог хариуцаж, борлуулалтын нэг ажилтан дунджаар 305 хэрэглэгч ногдож байгаа нь бусад аймгийн ижил төстэй байгууллагуудтай харьцуулахад 2-3 дахин бага байгааг тогтоосон байна.

Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны дундаж цалинг харьцуулан гаргасан судалгаагаар бусад аймгийн ижил төстэй байгууллагуудын цалингийн дундаж 1453.0-1910.6 мянган төгрөгийн хоронд байгаа бол “Суат”ХХК-ны дундаж цалин нь 1066.3 мянган төгрөг байна.

Энэ нь Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хамтын хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу “Нийтийн аж ахуйн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь тухайн онд Үндэсний статистикийн хорооноос жил бүр тогтоосон бүс нутгийн амьжиргааны баталгаажих доод түвшинг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байх...” гэсэн заалтыг хангахгүй байна.

Мөн бусад аймгуудын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компаниуд нь 4500-10000 төгрөгийн унаа хоолны хөнгөлөлт олгодог бол тус компани нь урамшуулалт цалин, хоолны хөнгөлөлт огт олгохгүй байгаа нь ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудал хангалтгүй байгааг харуулж байна.

Дээрх зөрчилтэй холбоотой 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 54-01-01/01 дугаар албан шаардлагаар бүтэц орон тоог шинэчлэн хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг үүрэг болгожээ.

Аудитын дүнгээр компанийн удирдлагын болон үйл ажиллагааны үр ашиггүй зардлыг бууруулах, ашигт ажиллагааг дээшлүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

1.2.5. Худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй байна

ЦШСГ нь 2023-2024 онд тендертэй холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дахь заалтын хүрээнд 2023 онд байгууллагын хөрөнгөөр 74.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй Холбооны-2 (дизель-ХХБ)-д шинээр кабель татах ажил, 39.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 110/35/10 дэд станц ба ЦРП хоорондох ЦДАШ татах ажлыг "Дар-Али" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Өлгий сумын төвд 2024 онд 37.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй АТП-67, АТП-74, КТПН-182 СИП солих ажил болон 34.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй ХТП-32 АТП-106 хооронд шинээр кабель татах ажлыг "Актив энэржи зон" ХХК-тай, 44.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 110/35/10кВ-ын дэд Өлгий станцаас 6кВт-ын Дизель станц хүртэлх Оролт-2-ын шугамын хөндлөн огтлолыг нэмэгдүүлэх (АС-120) ажлыг "Ногоон үйлс" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлэн бараа материалын дансанд орлого авсан байна.

Төсөвт өртөг нь 420.0 сая төгрөгийн үнийн дүнтэй БӨАЦШСГ/20240102007 дугаар бүхий тендерээр (1 багц) Ланд круйзер 76 маркийн автомашин, эксковатор, авто кран худалдан авахаар тендер зарлаж, "Монтех дистрибшн" ХХК-тай экскватор нийлүүлэх ажлыг 104.0 сая төгрөгөөр, "Их эрч" ХХК-тай авто кран нийлүүлэх ажлыг 128.0 сая төгрөгөөр гэрээ байгуулж, хөрөнгийг хүлээн авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Автомашин худалдан авах тендерт санал ирээгүй тул худалдан авалт хийгдээгүй байна.

Илрүүлэлт:

- ЦШСГ нь 2023-2024 онд худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1[2], 46 дугаар зүйлийн 46.1[3]-д заасны дагуу төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллаагүй байна.

- "ЕСМ Биллинг" ХХК-аас 55.0 сая төгрөгийн EDiMIS 3.0 программын шинэ хувилбарыг шууд гэрээ байгуулж худалдан авсан.

- Байгууллагад авсан 20.3 сая төгрөгийн компьютер, принтерийг цахим дэлгүүрээс худалдаж аваагүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн.

- 2023 онд 389.2 сая төгрөгийн, 2024 онд 360.2 сая төгрөгийн сэлбэгийг 5-6 ААНБ-аас, 2023 онд 113.5 сая төгрөгийн, 2024 онд 43.3 сая төгрөгийн шатахууныг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй, шууд худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

"Суат" ХХК нь мөн худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлэлгүй, цахим дэлгүүрийн системийг ашиглаагүй, бараа, материал, хөрөнгийг шууд худалдан авалт хийсэн байна.Тухайлбал:

---

[2] *Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална*

[2] *Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана*

“Мэйжүрмэт” ХХК-аас гэрээгээр 2023 онд 51.3 сая төгрөгийн, 2024 онд 8.9 сая төгрөгийн тоолуурыг, 2024 онд 21.1 сая төгрөгийн нормын хувцсыг, 2023 онд “Бек импекс” ХХК-аас Acer зөөврийн ширээний компьютер 1 ширхэг, 2024 онд “Сайко инвест” ХХК-аас Dell optiplex ширээний компьютер 1 ширхэг, Epson L3219 өнгөт принтер 1 ширхэг, “Нано хархорум” ХХК-аас Dell G15 зөөврийн компьютер 1 ширхэг, “Пирамид Софт Лайн” ХХК-аас Dell G-15 i7 зөөврийн компьютер 1 ширхэг нийтдээ 11.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авахдаа төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглаагүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй хувь хүн, хуулийн этгээдээс шууд худалдан авсан байна.

Аудитын дүнгээр худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу төлөвлөж, хэрэгжүүлэх, төрийн цахим худалдан авах системийг ашиглах талаар албан шаардлага өгөв.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА

2.1. Төрийн байгууллагуудаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдсэн байна

2.1.1. Эрх бүхий байгууллагуудаас хяналт шалгалт хийгдсэн байна

ЭХЗХ нь ЦШСГ-ын 2023-2024 оны цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг дүгнэсэн байна.

ЭХЗХ-ны 2023 оны 725 дугаар тогтоолоор баталсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-д биелэлтийг цахим системээр авч жил бүр дүгнэж, байхаар тусгасан байна.

Цахилгаанаар түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд 2023 онд дэвшүүлсэн 6 зорилтыг хянаж 80%-ийн, 2024 онд дэвшүүлсэн 5 зорилтыг хянаж 87.6%-ийн биелэлттэй, “сайн” үнэлгээтэй дүгнэсэн байна. *(Хавсралт 1-ээс харна уу)*

Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд 2023 онд дэвшүүлсэн 5 зорилтыг 80.7%-ийн, 2024 онд дэвшүүлсэн 6 зорилтыг 76.7%-ийн биелэлттэй, “сайн” үнэлгээтэй дүгнэсэн байна. *(Хавсралт 2-оос харна уу)*

Эрчим хүчний яамнаас салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдсэн байна. Шалгалтаар дараах зөрчлүүд илэрчээ. Үүнд:

Байгууллагын ашиглалтад байгаа тоног төхөөрөмж, байгууламжуудын техникийн паспорт дутуу, иж бүрдэл, хадгалалт хангалтгүй, хөтлөлт, баяжилт хийгдээгүй, трансформаторын дэд станцад гал унтраах суурин хэрэгсэл суурилуулаагүй, трансформатор, хаалттай дэд өртөөнүүдэд нэр, дугаар бичигдээгүй, насжилт өндөртэй, хуучирсан, 0.4-35 кВт-ын цахилгаан дамжуулах агаар шугамын модон тулгуурууд насжилт өндөртэй, засвар хийгдээгүй, цахилгаан

тоноглолуудад туршилт хийгдээгүй, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулаагүй, хариуцсан нэгж, ажилтангүй зэрэг 9 төрлийн зөрчил илэрч, хугацаатай албан шаардлага өгсөн байна.

Дээрх зөрчлүүдийг арилгах хүрээнд төлөвлөгөө батлуулж, биелэлтийг тайлагнасан байна.

“Суат” ХХК-ны 2023, 2024 оны үйл ажиллагаанд төрийн байгууллагуудаас дараах хяналт шалгалт хийгдсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, Онцгой байдлын газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын аймаг дахь газрын дарга, Цагдаагийн газрын дарга нарын хамтарсан 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр баталсан удирдамжийн дагуу тус компанийн барилга байгууламжид Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг үндэслэн хяналт шалгалт хийж албан шаардлага хүргүүлсэн байна. Албан шаардлагын хэрэгжилтийг хангаж 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 52 дугаар албан бичгээр хариу хүргүүлжээ.

Байгаль орчин аялал жуулчлалын газраас аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн эрүүл цэвэр орчныг хангах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/06 дугаартай удирдамжийн дагуу хяналт, шалгалт хийж “Рахат” халуун усны барилгын хог хаягдлыг ариутгах, зуухнаас гарсан үнсийг цэвэрлэх, тээвэрлэх арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлжээ. Уг албан шаардлагын хэрэгжилтийг хангаж 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 54 тоот албан тоотоор хариу хүргүүлсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч “Рахат” халуун усны барилгад хяналт шалгалт хийж 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр 10-15-02/072/12 тоот зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлжээ. Гарсан зөрчил дутагдлыг арилгаж 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 66 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн байна.

Аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын баталсан “Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалт”-ын удирдамжийн дагуу 2022, 2023 оны санхүүгийн баримтад 2024 оны 06 дугаар сард шалгалт хийж, 3.8 сая төгрөгийн төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлж, алданги ногдуулах акт тогтоосныг хугацаандаа барагдуулсан байна.

Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооноос 2025 оны 8 дугаар сард Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, усны үйлчилгээний тогтвортой байдал, үнэ тарифын хэрэгжилтийг шалгах удирдамжаар 2024 болон 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтаар Улсын ахлах байцаагчийн 2025 оны 09 дүгээр сарын16-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай“ 54-01-01/01 дүгээр албан шаардлагаар 8 төрлийн зөрчлийг арилгуулж, 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор биелэлтийг ирүүлэхээр хугацаатай албан шаардлага өгсөн байна.

2.1.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийсэн байна

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, албаны даргын баталсан удирдамжийн дагуу ЦШСГ, “Суат” ХХК-ны 2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаа, төсөв, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, НББ-ийн хөтлөлт, татвар, хураамж, өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад 2025 оны 3 дугаар сард шалгалт хийсэн байна.

ЦШСГ-т хийсэн шалгалтаар сахилгын шийтгэлтэй 13 албан хаагчид олгосон 8.3 сая төгрөгийн шагналт цалин, ажилчдын амралт, зугаалга, шинэ жилийн цэнгүүнд анхан шатны баримтгүй зарцуулсан 9.4 сая төгрөг, хувь хүнээс худалдаж авсан бараа материалын үнээс ХХОАТ суутгаагүй 15.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Хүлээн авалт, хүндэтгэл үзүүлэх, салбарын ойн баяр тэмдэглэх, шинэ жилийн арга хэмжээнд зарцуулсан 10.2 сая төгрөгийн, ажиллагсдад хамтын гэрээний дагуу олгосон 660.1 сая төгрөгийн шагналт цалин, дарга нарт ТУЗ-ийн шийдвэргүй олгосон 13.9 сая төгрөгийн шагналт цалин, ажиллагсдад тушаал гаргаагүй олгосон 39.9 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт, сумдын байцаагч нарт зарцуулалтын тооцоогүй олгосон 13.5 сая төгрөгийн шатахуун, тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж төсөвт өртгийг хуваах 768.5 сая төгрөгийн үнэ бүхий сэлбэг, кабель, тоолуур, концентатор худалдан авсан зөрчилд албан шаардлага өгч,

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, үр ашиггүй зардал гаргахгүй байх, шилэн дансны мэдээллийг хугацаанд мэдээлэх, тендерийн хуулийг мөрдөж ажиллах зэрэг зөвлөмж өгсөн байна.

“Суат” ХХК-нд хийсэн шалгалтаар 38.5 сая төгрөгийн төлбөрийн 6 акт тогтоосон байна.

Төлбөр хариуцагчаас дээрх актуудыг хүчингүй болгох гомдлыг Сангийн сайдад гаргаж, Сангийн яамнаас актуудыг хянаж Захиргааны Ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзэн Захиргааны Ерөнхий хуулийн 98 дугаар зүйлийн 98.1.2 дахь заалтад заасны дагуу хүчингүй болгон шийдвэрлэж 2025 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 01/3841 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас “Суат” ХХК-ны санхүүгийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар 2023 онд өгсөн акт, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг шалгаж үзэхэд төлбөрийн актын барагдалт 97.7 хувьтай, албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувьтай байна. 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

2.2. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА

2.2.1 ТУЗ-өөс хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна

ЦШСГ-ын Удирдах зөвлөлөөс хараат бусаар хяналт шалгалт хийх эрх бүхий дотоод аудитор томилж ажиллуулаагүй, Удирдах зөвлөлөөс хяналт хэрэгжүүлээгүй байна.

“Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд компанийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг хараат бус дотоод аудитор ажиллаагүй, төлөөлөн удирдах зөвлөлөөс хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын дүнгээр компанийн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж болгов.

2.2.2. Дотоод хяналтыг үр нөлөөтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна

ЦШСГ-ын Удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 10-ын өдрийн 02 дугаар тогтоолоор газрын дотоод хяналт, шинжилгээний ажилтныг томилсон ба Удирдах зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг үндэслэн ЦШСГ-ын “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг баталсан байна.

Дотоод хяналт, шалгалтын ажилтан нь дээрх журмыг удирдлага болгон ЦШСГ-ын 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөг Удирдах зөвлөлийн даргаар батлуулсан байна.

Төлөвлөгөөнд хууль тогтоомж, стандарт, заавар, дүрэм, журмын хэрэгжилт, үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарт хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт, өмч бүртгэлийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалт, санхүү бүртгэлд тавих хяналт, цахилгаан шугамын алдагдлыг бууруулах талаар хийгдэх хяналт, сумдад хийгдэх ээлжит хяналт, байгууллагын үйл ажиллагааны зардлыг багасгах, компанийг үр ашигтай ажиллуулах талаар арга хэмжээ авах зэрэг 8 чиглэлээр хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Дотоод хяналт шалгалтын ажилтны хийсэн ажилтай танилцахад төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй, хийсэн ажлаа Удирдах зөвлөлд танилцуулаагүй, ажлын тайлан гэх 2 хуудас тайлан бичсэн боловч нотлох баримтгүй, төлөвлөгөөнд заасан ажлуудыг тусгаагүй байна.

ТУЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоолоор байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбоотой дотоод хяналт, шинжилгээний ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлсөн байна.

Илрүүлэлт:

Дотоод хяналт шалгалтын журмыг хэрэгжүүлээгүй, дотоод хяналт шалгалт нэр төдий хийгдсэн байна.

Аудитын дүнгээр холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн дотоод хяналт шалгалтын журмыг шинэчлэн баталж, дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

"Суат" компанийн бүтэц орон тоонд 2016 оноос эдийн засагч, дотоод аудиторын орон тоог бий болгож ажиллуулж ирсэн байна.

Дотоод аудитын ажлын төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой баримт материалыг аудитад ирүүлээгүй. Дотоод аудиторын үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах асуудал хангалтгүй байна.

"Суат" ХХК-ийн гүйцэтгэх удирдлага нь 2020 онд компанийн дотоод хяналт шалгалтын нэгжийг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгжийн 2023-2024 онд хийх ажлын төлөвлөгөөг ТУЗ-ийн даргаар батлуулан хэрэгжүүлж, биелэлтийг ТУЗ-ын даргад илтгэх хуудсаар танилцуулсан байна.

Нэгж нь 2023 онд санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтын хүрээнд 5, хөндлөнгийн хяналт шалгалтын хүрээнд 4, бүгд 9 ажил төлөвлөж, 77.7 %-ийн биелэлтэй тайлагнасан. 2024 онд 8 ажил төлөвлөснөөс 7 ажил нь хэрэгжиж 87.5%-ийн биелэлтэй байна.

Төлөвлөгөөнөөс гадуур борлуулалтын байцаагч нарын үр дүнгийн цалинд нэмж оруулсан борлуулалтын орлогын 5%-иар тооцож хийснээрх цалин олгож байгаа нь дотоод журам болон хөдөлмөрийн тухай хууль, хамтын гэрээнд тусгагдаагүй, зохицуулалт хийгдээгүй байсан зөрчлийг илрүүлж 2024 оны 9 дүгээр сараас зогсоох арга хэмжээ авч ажилласан байна.

Мөн 2023 оны 9 дүгээр сард хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 3 хүний бүрэлдэхүүнтэй лабораторид ашиглаж буй химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, ашиглалт, лабораторийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Химийн бодисын тухай хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж 6 зөрчил дутагдал илрүүлж, цаашид засаж сайжруулах чиглэл өгч ажилласан байна.

Үүний үр дүнд захирлын 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/23 дугаар тушаалаар "Лабораторийн үйл ажиллагааны дүрэм", "Химийн бодис ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг шинэчлэн батлуулсан байна.

Аудитын дүнгээр компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

2.2.3. Шилэн дансны зарим мэдээллийг ил тод байршуулаагүй байна

ЦШСГ нь https://ulgiienergy.mn/ вэб сайтаар компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл, үнэ тариф, удирдах албан тушаалтнуудын танилцуулга, бүтэц зохион байгуулалт, ТУЗ-ийн урамшууллын мэдээллийг байршуулсан байна.

Мөн Вэб сайтад хэрэглэгчдэд санал хүсэлт гаргах булан ажиллуулж, пэйж хуудаснаас иргэд шууд шилэн дансны мэдээлэлтэй танилцахаар холбосон байна.

Түүнчлэн “Olgiitog” нэртэй Facebook пейж хуудас ажиллуулж, өдөр тутмын мэдээ, мэдээллийг байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх үүрэгтэй.

ЦШСГ-ын 2023-2024 оны шилэн дансны мэдээллийг тулган шалгахад Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс 149 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг байршуулаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухайн хуулийн 3.1.3-д заасны дагуу ОНӨААН нь хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4-д заасан мэдээллүүдийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулах үүрэгтэй боловч дээрх мэдээллүүдийг ил тод мэдээлж ажиллаагүй байна.

“Суат” ХХК нь 2017-2019 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй хөтөлбөрийн дэмжлэгээр хөгжүүлсэн suat.water-mongolia.com гэсэн вэб сайтыг 2024 он хүртэл ажиллуулж компанийн танилцуулга, эрхэм зорилго, алсын хараа, зорилтууд, орон тоо, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, холбогдох хууль тогтоомжийн жагсаалт болон цаг үеийн мэдээ мэдээллийг байршуулсан байна.

Вэбсайтад хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээний үнэ тариф, усны тооцоолуур, санал хүсэлт өргөдөл гомдол хүлээн авах, түгээмэл асуулт хариулт, зөвлөмж өгөх булан ажиллуулжээ.

Компани нь 2025 оноос тус вэбсайтыг шинэчилж suat-llc.mn гэсэн шинэ сайтыг нэвтрүүлж байгаа ба “Баян-Өлгий аймгийн НААҮ-ний “Суат” ХХК гэсэн цахимыг хуудсыг нээн ажиллуулсан байна.

Шилэн дансны мэдээллийг шалгахад 2023 онд 159.8 сая төгрөгийн 24 гүйлгээний мэдээлэл, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 57.6 сая төгрөгийн 32 шийдвэр, 2024 онд 51.6 сая төгрөгийн 32 шийдвэрийг ил тод байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгөв.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНӨААН-үүдийн засаглал, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар үр дүнтэй бодлого, шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

2. Үйл ажиллагааны эдийн засгийн үзүүлэлтүүдийг бодитой төлөвлөөгүй, зорилт түвшний зарим үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байна.

3. Удирдлагын зардлыг тусад нь төлөвлөж, үр ашигтай зарцуулах талаар хангалтгүй ажилласан байна.

4. Үйл ажиллагааны зардлыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, үр ашиггүй зардлыг бууруулах талаар хангалтгүй ажилласан байна.

5.ЦШСГ-ын тендерийн орлого, зардлын бүртгэлийг үнэн зөв хөтөлж, ашигт ажиллагааг тооцож тайлагнаагүй байна.

6.Худалдан авах ажиллагааг зохих журмаар төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.

7.Дотоодын хяналтыг үр нөлөөтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Цахилгаан шугам сүлжээний газрын дарга /Ө.Арманбек/-д:

1. Үйл ажиллагааны орлого, зардлыг үндэслэлтэй төлөвлөх, удирдлагын зардлыг тусад нь төлөвлөх, бизнес төлөвлөгөө, хүрэх түвшнийг эдийн засгийн үзүүлэлт тус бүрээр ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар батлуулж ажиллах;
2. Үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, ашигт ажиллагааг дээшлүүлэхэд анхаарах;
3. Бусад орлогыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах, Үйлдвэрчний эвлэлийн орлого, зарцуулалтын тооцоог баталгаажуулж байх;
4. Ажиллагсдын ажлыг үнэлэх, дүгнэх журам баталж, ажлын үр дүнг бодитой дүгнэж байх;
5. Байгууллагын дотоод хяналт шалгалтын журмыг шинэчлэн баталж, дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх;

II. “Суат” ХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Нурбек/-д

1. Компанийн орлого, зардлын эдийн засгийн үзүүлэлтүүдийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулах;
2. Төсөвт байгууллагын усны төлбөрийг тоолуурын заалтаар авах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, төлбөрт үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах;
3. Зардал хэмнэх, үр ашиггүй зардлыг бууруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэхэд анхаарах;
4. Дотоод хяналтыг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах;

III. Цахилгаан шугам сүлжээний газрын Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Цахилгаан шугам сүлжээний газрын засаглал, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар бодлого, шийдвэр гаргаж ажиллах

IV “Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Компанийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавьж ажиллах, үр ашгийг дээшлүүлэх;
2. Компанийн гүйцэтгэх захиралд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлах;

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

СУАТ
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
"СУАТ" ХХК
83129 Баян-Өлгий аймаг, Өлгий сум
Утас/Факс: (976) 70422112, E-mail: Ulgii_suat@yahoo.com

2025.10.10 178

танай _____ -ны № _____ -т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр ашиг" сэдэвт 2023-2024 оныг хамруулж хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан ба ямар нэгэн хүргүүлэх санал байхгүй болно.

ЗАХИРАЛ С.НУРБЕК

СУАТ ХХК

Alban bichig-2025

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР

83127 Өлгий сум, Баян-Өлгий аймаг
Утас/Факс:(976) 70422769
Цахим шуудан:tsahilgaan.ulgii@gmail.com
Цахим хуудас:www.ulgiienergy.mn

2025.10.20 № 463

танай_____-ны №_____-т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн "Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр ашиг" сэдвээр 2023–2024 оныг хамруулсан гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Уг тайланд онцгой санал байхгүй бөгөөд гүйцэтгэлийн аудитын явцад тавигдсан албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд тусган ажиллах болно.

Мөн аудитын явцад тавигдсан актыг шаардагдсан хугацаанд биелүүлж, биелэлтийн талаар танай байгууллагад мэдэгдэх болно.

ДАРГА Ө.АРМАНБЕК

ОНӨААТҮГ
0225050032 дд 2004607

832500402

Хавсралт №01 *Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 2023 оны зорилтын биелэлт*

№	2023 онд мөрдөх зорилт	Авах оноо	Биелэлт
1	Цахилгаан түгээх, хангах үйл ажиллагааг осол, аваар, сааталгүй явуулах, гарсан аваар, саатал, тасралтыг тухай бүрт нь холбогдох мэргэжилтэнд шуурхай мэдээлэх, тайлагнах	20	11.5
2	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ний ажлуудыг эрсдлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлж төлөвлөн, бүрэн хийж гүйцэтгэх, томоохон үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ний ажлуудын хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг тооцож ирүүлэх, цахилгаан түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх 3-5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг жил бүр тодотгож ирүүлэх	20	20
3	Цахилгаан түгээлтийн алдагдлыг тухайн онд тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй ажиллах	10	0
4	Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хэмнэлтийн төлөвлөгөөний дагуу эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	10	9.7
5	Цахилгаан хангамжийн тасалдлын индексүүдийг өмнөх оноос бууруулах	10	10
6	Баталсан тарифт тусгагдсан борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг үр ашигтай зарцуулж ажиллах	30	28.8
	Нийт оноо	100	80

№	2024 онд мөрдөх зорилт	Авах оноо	Биелэлт
1	Цахилгаан түгээх сүлжээний / ЦТС/ аюулгүй, найдвартай ажиллагааг хангах, осол, аваар, сааталгүй ажиллах	20	13.85
2	Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, техникийн болон арилжааны алдагдлыг бууруулах	20	20
3	Цахилгаан түгээх сүлжээний ашиглалт засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийн ажлыг эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах	20	18.46
4	Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах	30	26.7
5	Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	10	8.6
	Нийт оноо	100	87.61

Хавсралт №02 *Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 2024 оны зорилтын биелэлт*

№	2023 онд мөрдөх зорилт	Авах оноо	Биелэлт
1	Цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг оны эхэнд баталсан төлөвлөгөөнөөс ±2 хувиас хэтрүүлэхгүй байх, худалдан авсан цахилгааны төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх	15	11.25
2	Ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх, хүрсэн үр дүн, компанийн алдагдалд хэрхэн нөлөөлсөн талаар иж бүрэн шинжилгээ хийсэн байх	20	16
3	Цахилгаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаатай холбоотой хэрэглэгчээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хууль ёсны эрх ашгийг нь хангаж ажиллах	25	22.5
4	Цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах	10	10
5	Нийт авлага, богино хугацаат өр төлбөрийг оны эхний үлдэгдлээс бууруулах, санхүүгийн зохистой харьцаануудыг хангаж ажиллах	30	21
	Нийт оноо	100	80.75

№	2024 онд мөрдөх зорилт	Авах оноо	Биелэлт
1	Цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг оны эхэнд баталсан төлөвлөгөөнөөс ±2 хувиас хэтрүүлэхгүй байх	10	3
2	Хэрэглэгчийг стандарт, норм, дүрмийн шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангаж, цахилгаан тасалдлын индексүүдийг өмнөх оноос бууруулах	10	10
3	Хэрэглэгчдэд борлуулсан цахилгааны төлбөрийг бүрэн төвлөрүүлэх, цахилгаан худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авсан цахилгааны төлбөрийг бүрэн төлөх	25	20
4	Хэрэглэгчдэд цахилгаан худалдахад урьдчилсан төлбөрт болон ухаалаг тоолуурын системийг жил бүр нэвтрүүлэх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх	15	12
5	Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангаж ажиллах, хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, бүрэн шийдвэрлэх	25	23.75
6	Санхүүгийн зохистой харьцааг хангаж цахилгаан эрчим хүчний өр, төлбөрийг өсгөхгүй байх	20	8
	Нийт оноо	100	76.75

Хавсралт №03 “Суат” ХХК-ны *Удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа* (*төгрөгөөр)*

Үзүүлэлт	Төлөвлөгөөний харьцуулалт		Зөрүү	2024 он		2024 оны хэтрэлт, хэмнэлт
	2023 он	2024 он	2024-2023	төлөвлөгөө	гүйцэтгэл	
7011-0001 - Үндсэн цалин - Захиргаа	149,340,499.2	215,857,119.0	66,516,619.8	215,857,119.0	184,827,655.5	(31,029,463.5)
7011-0005 - Үндсэн цалин - ТУЗ	9,020,000.0	22,800,000.0	13,780,000.0	22,800,000.0	20,200,000.0	(2,600,000.0)
7013-0001 - НДШ, ЭМД - Захиргаа	20,160,967.4	29,140,711.0	8,979,743.6	29,140,711.0	23,399,806.0	(5,740,905.1)
7013-0005 - НДШ, ЭМД - ТУЗ			-		2,525,000.0	2,525,000.0
7021-0001 - Халаалт дулаан - Захиргаа	11,662,525.4	13,714,050.0	2,051,524.6	13,714,050.0	21,910,798.6	8,196,748.6
7022-0001 - Цахилгаан - Захиргаа	2,332,470.6	5,695,464.0	3,362,993.4	5,695,464.0	2,917,999.0	(2,777,465.0)
7024-0001 - Шуудан холбоо, интернэт - Захиргаа	4,126,000.0	2,131,900.0	(1,994,100.0)	2,131,900.0	1,527,272.7	(604,627.3)
7031-0001 - Урсгал засвар - Захиргаа	2,000,000.0	5,000,000.0	3,000,000.0	5,000,000.0	222,090.9	(4,777,909.1)
7032-0001 - Засвар үйлчилгээний зардал - Захиргаа			-		267,727.3	267,727.3
7041-0001 - Дотоод албан томилолт - Захиргаа	8,000,000.0	13,020,000.0	5,020,000.0	13,020,000.0	15,098,318.2	2,078,318.2
7043-0001 - Сургалтын зардал - Захиргаа	1,000,000.0	17,250,000.0	16,250,000.0	17,250,000.0	8,814,391.8	(8,435,608.2)
7051-0001 - Элэгдлийн зардал - Захиргаа	20,983,827.3	22,228,664.0	1,244,836.7	22,228,664.0	24,214,480.4	1,985,816.4
7071-0001 - Бичиг хэргийн зардал - Захиргаа	1,456,250.0	4,980,190.0	3,523,940.0	4,980,190.0	3,301,526.8	(1,678,663.3)
7072-0001 - Хөдөлмөр хамгааллын зардал - Захиргаа	3,300,000.0	4,950,000.0	1,650,000.0	4,950,000.0	12,005,954.6	7,055,954.6
7073-0001 - Хангамжийн материалын зардал - Захиргаа	4,000,000.0	2,984,576.0	(1,015,424.0)	2,984,576.0	2,011,218.2	(973,357.8)
7074-0001 - Түлш шатахууны зардал - Захиргаа	15,000,000.0	13,166,090.0	(1,833,910.0)	13,166,090.0	11,262,300.0	(1,903,790.0)
7077-0001 - Сэлбэг хэрэгсэл - Захиргаа	1,000,000.0	6,000,000.0	5,000,000.0	6,000,000.0	1,200,454.6	(4,799,545.5)
7081-0001 - Автомашины татвар,даатгал,оношилгоо - Захиргаа	113,626.7	269,064.0	155,437.3	269,064.0	140,000.0	(129,064.0)
7084-0001 - Даатгалын зардал - Захиргаа	1,140,477.3	1,500,000.0	359,522.7	1,500,000.0	1,346,840.9	(153,159.1)
7091-0001 - Бусад зардал - Захиргаа	15,500,000.0	17,061,200.0	1,561,200.0	17,061,200.0	20,864,709.6	3,803,509.6
7092-0001 - Зар сурталчилгааны зардал - Захиргаа	300,000.0	833,600.0	533,600.0	833,600.0	582,000.0	(251,600.0)
7095-0002 - Банк хооронд бэлэн бус гүйлгээний шимтгэл			-		451,254.0	451,254.0
ҮХХ-ийн татвар	707,924.9	192,188.0	(515,736.9)	192,188.0		(192,188.0)
Тээврийн зардал	400,000.0		(400,000.0)			-
Тоног төхөөрөмж		5,500,000.0	5,500,000.0	5,500,000.0		(5,500,000.0)

Дүн	**271,544,568.6**	**404,274,816.0**	**132,730,247.4**	**404,274,816.0**	**359,091,798.8**	**(45,183,017.2)**